




2025 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЖИЛИЙН ТАЙЛАН



ДЭЛХИЙ РҮҮ ТЭМҮҮЛСЭН 20 ЖИЛ

Website: www.monlogistics.mn
Phone: 7701 5454

01 Бидний тухай

Компанийн тухай	5
Хуулийн этгээдийн мэдээлэл	6
Үнэт зүйлс	7
Группийн бүтэц	8
Группийн түүхэн замнал	9
ТУЗ-ийн даргын мэндчилгээ	11
Группийн гүйцэтгэх захирлын захидал	13
Онцлох санхүүгийн үзүүлэлт	15
Онцлох үйл явдал	19
Онцлох тээвэр	21

02 Зах зээл ба стратеги

Дэлхийн тээвэр ложистикийн салбар	25
Монголын тээвэр ложистикийн салбар	27
Монложистикс Групп	28
Алсын хараа 2030	29
2030 стратеги	30
Бизнес модель	30
Санхүүгийн үзүүлэлт	32
Группийн гүйцэтгэл - Импорт	34
Группийн гүйцэтгэл - Экспорт	35
Группийн гүйцэтгэл - Транзит	36
Группийн гүйцэтгэл - Бусад	37
2026 оны зорилт, хөрөнгө оруулалт	38

03 Тогтвортой хөгжил

Нийгэм ба байгаль орчин	41
Хүний нөөцийн бодлого	43
Өндөр чадвартай мэргэжлийн хамт олон	43
Инновацилаг багийн сэтгэлгээ	46
Бусдыг хүчирхэгжүүлэх манлайллын соёл	46
Шудрага, ил тод байдал	47
Хариуцлага, сахилга бат	48

04 Засаглал

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц	51
Хувьцаа эзэмшигчдийн хурал	51
Төлөөлөн удирдах зөвлөл	52
ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тайлан	53
Засаглалын зарчмуудын хэрэгжилт, өөрийн үнэлгээ, хянан баталгаажилт	55
Гүйцэтгэх удирдлагын баг	57
Хувьцааны мэдээлэл	59
Ногдол ашгийн бодлого	60
Оролцогч талуудтай харилцах стратеги	61

05 Хяналтын тогтолцоо

Хяналтын тогтолцоо	65
Эрсдэлийн удирдлага	66
Нийцлийн удирдлага	66
Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл	67
ISO 9001:2015	67
Хөндлөнгийн баталгаажуулалт	67

06 Санхүүгийн тайлан

Нэгтгэсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	71
Нэгтгэсэн санхүү байдлын тайлан	72
Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	73
Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	75
Тайлагналын зарчим	76
Тайлбар толь	77

Бидний тухай

Монложистикс Групп нь өдөр тутмын өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг импортлохоос эхлэн уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлох, хөрш орнуудыг ачаа тээврээр холбох зэрэг тээвэр ложистикийн бүх төрлөөр олон улсын стандартад нийцсэн тээврийн цогц үйлчилгээг үзүүлдэг Монголын No.1 тээвэр ложистикийн компани юм.

800+


160 ГАРУЙ ОРНЫ ХАРИЛЦАГЧ

1500+

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ

210+

АЖИЛТАН



КОМПАНИЙН ТУХАЙ

2005 онд Монгол Улсад тээвэр зуучийн үйлчилгээний нэгэн шинэ хуудсыг эхлүүлж, цөөн хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдаж байсан Монложистикс Групп 2025 онд 20 нас хүрлээ. Анх арваадхан хүнтэй үйл ажиллагаа эхлүүлж байсан Монложистикс Групп нь өнөөдөр 1 толгой компани, 7 охин компани, 210 гаруй ажилтан, дэлхийн 163 орны 800 гаруй харилцагч түнш, дотоодын 1500 гаруй үйлчлүүлэгчтэй Монгол Улсын тээвэр ложистикийн салбарын тэргүүлэгч групп компани болон өргөжин тэлжээ.

Өнгөрсөн 20 жилийн хугацаанд бид Монгол Улсын эдийн засгийн чухал салбар болох тээвэр ложистикийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж, иргэдийн өдөр тутмын өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг импортлохоос эхлэн уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлох, хөрш болон гуравдагч орнуудыг ачаа тээврээр холбох хүртэл импорт, экспорт, транзит зэрэг тээвэр ложистикийн бүх төрлийн үйлчилгээг агаараар, усан замаар, авто тээврээр, төмөр замаар гээд тээврийн бүхий л төрлөөр олон улсын жишигт нийцүүлэн үзүүлсээр ирлээ.

20 жилийн турш бид харилцагчид, ажилтнууд, түншүүдийнхээ итгэл дээр тулгуурлан, инновац, чанар, хариуцлагыг эрхэмлэн ажиллаж ирсэн бөгөөд энэ хугацаанд бизнесийн тогтвортой өсөлт, менежментийн шилдэг туршлага, дотоодын болон олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай групп компанийг бий болгожээ. Монложистикс Холдинг ХК нь группийн охин компаниудын бодлого, стратеги, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангаж, тэдгээрт хүний нөөц, санхүү, мэдээллийн технологи, маркетинг, стратеги ба бизнес хөгжил, ложистик гэсэн 6 чиглэлд менежментийн үйлчилгээ үзүүлж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг толгой компани юм.

ЭРХЭМ ЗОРИЛГО

**ДЭЛХИЙ РҮҮ ТЭМҮҮЛЭХ
ҮНДЭСНИЙ БРЭНД**

АЛСЫН ХАРАА

Бид 2030 онд орчин үеийн дэд бүтэц, үйлчилгээний чанар дээр суурилсан цогц ложистик үйлчилгээг нэвтрүүлж, улмаар Монгол Улсыг Ази Европыг холбосон ложистик төв болгоно.

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

Оноосон нэр:

Монложистикс Холдинг ХК

Хэлбэр:

Нээлттэй хувьцаат компани

Регистрийн дугаар:

6381251

Бизнесийн үндсэн үйл ажиллагааны чиглэл:

**Менежментийн зөвлөх үйлчилгээ,
төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх**

Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага:

Монголын Хөрөнгийн Бирж

МХБ-ийн хувьцааны бүртгэлийн индекс:

**Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20
Хувьцааны бүртгэлийн I ангилал**

Монголын Хөрөнгийн Бирж дээрх симбол:

MSE:MLG

Утас:

+976 7701-5454

Имэйл:

info@monlogistics.mn

Вэбсайт:

www.monlogistics.mn

Фэйсбүүк хуудас: **Monlogistics Group**

Албан ёсны хаяг:

**Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Олимпын гудамж, Нью
Хоризонс оффис, 1101 тоот**



ҮНЭТ ЗҮЙЛС



Өндөр чадвартай, мэргэжлийн хамт олон

Ажилтан бүр өөрийгөө олж нээн, авьяас чадвараа суралцах их хүсэл эрмэлзлээр хөгжүүлэн, оюун ухаан, хүч хөдөлмөрөө харамгүй зориулснаар өөртөө болон байгууллагад амжилт бүтээл дагуулж, бусдадаа үлгэрлэн манлайлах замаар дараагийн залгамж манлайлагч нарыг тасралтгүй төрүүлдэг байна.



Инновацлаг багийн сэтгэлгээ

Манай хамт олон инновац, бүтээлч сэтгэлгээгээрээ багийн үйл ажиллагааг тасралтгүй сайжруулан төгөлдөршүүлэхийн төлөө цаг үетэй хөл нийлүүлж, техник технологийн хөгжлийг хурдтай нэвтрүүлж, байнга шинийг санаачлагч багуудаас бүрдэнэ.



Хариуцлага, сахилга бат

Манай байгууллагын ажилтан бүр өөрийн хариуцсан ажлыг хийхдээ хувийн өндөр сахилга баттай байж, ажилдаа өөриймсөг сэтгэлээр хандаж, Монгол Улсын хууль тогтоомж, Группийн дотоод үйл ажиллагааны стандартыг ёс зүйтэй мөрдөж, ямар ч ажлыг туйлын хариуцлагатайгаар, чанар стандартын дагуу гүйцэтгэдэг байна.



Бусдыг хүчирхэгжүүлэх манлайллын соёл

Манай ажилтан бүр тасралтгүй суралцан, мэдлэг оюунаа тэлж, мэргэжлийн болон ерөнхий ур чадвараар цаг үетэйгээ үргэлж нийцэж, дэлхийн өнцөг булан бүрийн аль ч компанид тэнцэн ажиллах чадамж бүхий зорилго нэгт баг хамт олны нэг хэсэг байна.




Шударга, ил тод байдал

Манай бүх үйл ажиллагаа том жижиг, их багаас үл хамааран үнэнч шударга байх зарчим дээр суурилан бүхий л оролцогч талуудад шаардлагатай мэдээллийг нээлттэй ойлгомжтой, үнэн зөвөөр цаг ямагт хүргэж байх болно.



ГРУППИЙН БҮТЭЦ

Монложистикс Групп нь толгой компани болох Монложистикс Холдинг ХК болон түүний охин компаниуд гэсэн бүтэцтэйгээр ажилладаг. Монложистикс Холдинг ХК нь охин компаниудын бодлого, стратеги, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, тэдэнд менежментийн үйлчилгээ үзүүлж, стратегийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллаж байна.



Монложистикс Экспресс ХХК, Монложистикс Тракинг ХХК-иуд нь 2026 оноос Монложистикс Ворлдвайд ХХК-тай бүтэц, үйл ажиллагаагаа нэгтгэсэн.

ТҮҮХЭН ЗАМНАЛ

2005 он



Монложистикс
Ворлдвайд ХХК
ууган компани
байгуулагдав.

2006 он

Монголын Тээвэр
зуучийн нэгдсэн
холбоонд албан ёсны
гишүүнээр элсэв.

2009 он



Төмөр замын аюулгүй
ажиллагааны тусгай
зөвшөөрлийг хүлээн
авав.

monlogistics
TRANSIT
Монложистикс Транзит ХХК
байгуулагдав.



Оюу толгой компанийн
албан ёсны тээврийн
компаниар шалгарав.

Бүх тээврийг даатгалд
хамруулах үйлчилгээг
нэвтрүүлэв.

2019 он

monlogistics
HOLDING
Монложистикс Холдинг ХХК
Толгой компани байгуулагдав.

2018 он

monlogistics
TRUCKING
monlogistics
TRANS SERVICE

Портфолио өргөжилт
хийж, 3 охин компаниа
байгуулав.

2017 он

kausaustralis
Түүхий эдийн экспортын
тээврийг эхлүүлж,
Каус Аустралис ХХК-ийг
байгуулав.

2020 он

2021 он

2022 он

2010 он

Монгол Улсын Гаалийн
ерөнхий газраас Гаалийн
зуучлагчийн тусгай
зөвшөөрлийг авав.



2011 он

Монголын гаалийн
зуучлагчдын нэгдсэн
холбооны гишүүнээр
элсэв.

Rebranding
“Upgrade 10” төслийг
амжилттай эхлүүлэв.



ISO 9001:2008 Олон
улсын чанарын
удирдлагын
тогтолцоог
нэвтрүүлэв.

Олон улсын тээвэр
зуучийн нэгдсэн
холбоонд албан ёсны
гишүүнээр элсэв.

2016 он



Монложистикс Холдинг ХХК
Олон нийтэд нээлттэй
компани болов.

2015 он



Төв Азийн Зам ХХК-ийн
51%-ийг худалдан авч,
M&A хийв.

2014 он



Компанийн үүсэн
байгуулагдсаны
20 жилийн ой тохиов.

2023 он

2024 он

2025 он



“

**ӨНГӨРСӨН ХОРИН ЖИЛИЙН ХУГАЦААНД
БИЗНЕСИЙН ҮР АШГААС ИЛҮҮТЭЙ САЛБАРТАА
ШИНЭ СОЁЛ, ЛОЖИСТИКИЙН ШИНЭ ШИЙДЭЛ,
МЕНЕЖМЕНТИЙН СТАНДАРТ, ХАРИУЦЛАГЫН
ЖИШИГ ТОГТООЖ ЧАДСАН НЬ БИДНИЙ ГОЛ
АМЖИЛТ ЮМ.**

”

ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

Монложистикс Групп үүсгэн байгуулагдсанаас хойш 20 жилийг үджээ. 2025 онд тэмдэглэн өнгөрүүлсэн ойн арга хэмжээ нь өнөөдөр бидний эгнээнд нэгдэн ажиллаж буй залуу үеийнхэн, бидний үйлчлүүлэгч, харилцагч, хамтран ажиллагч зэрэг бизнесийн бүхий л оролцогч талуудад компанийн туулж ирсэн түүхэн замнал, баримталж ирсэн зарчмууд, бий болгосон үнэт зүйлүүдээ онцолж дүгнэсэн үйл явдал болж өнгөрлөө. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд Монложистикс Группийн хүрсэн амжилт, бий болгосон олон арван зүйлсийг бүгдийг дурдах боломжгүй ч, дараах гол ололтуудыг Та бүгдэд толилуулбал:

- Тээвэр ложистик хийгээд Монголын бизнесийн салбарт Монложистик хэмээх нэрийг тодоос тод гарган, итгэл даагч, найдвартай байдал, үргэлж амжилт бүтээлээр дүүрэн явахын илэрхийлэл болгон, өнөөдрийг хүртэл хиргүй тунгалаг авч ирж чадсан нь бүх цаг үеийн Монложистикчуудын түүхэн гавьяа юм.
- Шударга, ёс зүйтэй харилцаа, ил тод байдлыг дээдлэн баталгаажуулахад тулгуурласан, ямагт шинэлэг санаа, инновацийг эрэлхийлж алба нэгж, ажилтны хүрээнд тасралтгүй хөгжил сайжралтыг дэмжих компанийн дотоод соёлыг бий болгон хэвшүүлж, компанийн бодлогын баримт бичгүүдэд тусган ирээдүй үеийнхэний хүртээл болгосон нь бас нэгэн том ололт байсан.
- Бүх шатны хариуцлага, сахилга баттай байдлын үндэс, өргөн цар хүрээт стратеги төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлэх, чин шударга тайлагнал, бизнесийн оролцогч талуудын эрх ашгийг тэнцүүхэн хадгалах, хүндлэн хамгаалах үндсэн чиг үүрэгтэй засаглалын системийг бий болгож чадсан.

Эдгээр ололтуудыг Монложистикс хэмээх өрх айлын тулгын гурван чулуу хэмээн тодорхойлвол дараагийн олон арван жилүүдэд зогсолтгүй урагшаа тэмүүлж, үйл ажиллагааг солонгоруулан хөгжүүлэх, аль ч салбарт манлайлах уламжлалаа үргэлжлүүлэн явах бат бөх суурийг тавьж, үргэлж дүрэлзэх галыг асааж чадсан нь хамгийн том амжилт байв.

Өнгөрсөн үеийн түүхэн ялалтын уламжлалаа үргэлжлүүлэн, өөрсдийн хүч хөдөлмөрөөр бий болгосон үндэс суурь, үнэт зүйлсээ улам бэхжүүлж, дэлхий рүү тэмүүлэн олон улсын тавцанд Монголын нэрийг тамгалсан компани болох гэгээн хүслээр жигүүрлэсэн хамт олон бүрэлдэн бий болсныг та бүхэнд бахдан дуулгахад таатай байна

Хүндэтгэсэн,

Л.ГАНЗОРИГТ

ТУЗ-ИЙН ДАРГА, ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ

ГРУППИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ЗАХИДАЛ



Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, түншүүд болон үйлчлүүлэгч нартаа 2025 оны жилийн эцсийн тайлангаараа мэндчилж байна!

Монложистикс Группийн хамт олон анх үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш 20 дахь жилдээ нийт үнэнч хэрэглэгчид, харилцагчдынхаа ачааг шаргуу тээвэрлэж, тэсвэр хатуужил, өсөлт, стратегийн ахиц дэвшлээр дүүрэн жилийн үр дүнгээ та бүхэнтэй хуваалцаж байгаадаа баяртай байна. Эдийн засгийн болон зах зээлийн сорилт ихтэй 2025 оны санхүүгийн жилд Монложистикс Групп 809 мянган тонн ачаа тээвэрлэж, 285 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж үүнээс 21 тэрбумын нийт ашиг, 10 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллалаа. Энэхүү амжилт нь 210 гаруй ажилтан, 1500 гаруй дотоодын үйлчлүүлэгч, дэлхийн 163

орны 800 гаруй гадаадын түнш байгууллагуудын тасралтгүй итгэл, хамтын хүчин чармайлтын үр дүн болохыг онцгойлон тэмдэглэхийг хүсч байна.

Өнгөрсөн жилийн стратегийн гол ололт амжилтуудаас дурдвал:

- Хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт: ОХУ-аас 50 ширхэг ачааны хагас вагон худалдан авсан нь бидний 2030 он хүртэлх стратегийн нэг тулгуур болох импортын хамааралтай бизнесийн бүтцээс экспортод чиглэсэн, өндөр өгөөжтэй сегмент рүү шилжих стратегийн чухал алхам боллоо. Цаашид бид хувьцаа эзэмшигчиддээ амласан ёсоор, эдийн засаг, зах зээлийн нөхцөл байдал болон Төмөр замын тээврийн тухай хуулийн бодит хэрэгжилт дээр үндэслэн дахин 50 ширхэг буюу 2 дахь цуваагаа авахаар төлөвлөн ажиллаж байна.
- БНХАУ-д салбар охин компани байгууллаа: Өөрийн нийт харилцагчдын дийлэнхийг нь бүрдүүлдэг импортын сегментийн үйлчилгээ, үнэ болон тогтвортой байдлыг хангах зорилго бүхий шинэ компанийн бүтцийг БНХАУ-ын Тяньжин хотод байгуулж, үйл ажиллагааг эхлүүлээ. Ингэснээр Монложистикс групп нь дэлхийн далайн тээврийн компаниуд, Хятадын төмөр зам зэрэг стратегийн чухал түншүүдтэй шууд хамтын ажиллагааг эхлүүлсэн ба ирээдүйд Монголын бус бизнесийг хөгжүүлэх эхлэл тавигдаж байна.
- Технологийн шилжилт: Цаг, өдрөөр хувьсан өөрчлөгдөж байгаа технологийн хөгжилтэй хөл нийлүүлэх зорилгоор бид өмнөө зоригтой зорилго тавин томоохон өөрчлөлтүүдийг хийж байна. Харилцаа холбоог сайжруулах, дотоод автоматжуулалт, гинжин хэлхээний бүтээмжийг өсгөх зорилго бүхий урт хугацааны төсөл нь эхнээсээ үр дүнгээ өгч, бодит амьдралд нэвтэрч, биднийг маш сонирхолтой ба маш хурдтай ирээдүй хүлээж байгааг баталлаа.

- Дотоод бүтэц зохион байгуулалт: Өнгөрсөн 5 жилийн хугацаанд эрчимтэй өсөж буй зах зээлд Монложистикс Групп мөн өөрийн үйл ажиллагааг эрчимтэй тэлсэн. Харин 2025 онд бид дотоод бүтэц, зохион байгуулалт, менежментэд бүтээмжийг сайжруулах, хурдыг нэмэгдүүлэх, эмх цэгц, төвлөрлийг сайжруулах зорилгоор группийн охин компаниудын бүтцийн өөрчлөлт, процессийн сайжруулалт, дотоод дүрэм журмыг хялбаршуулах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.
- Засаглал, нийгмийн ажлууд: Компани нь ногдол ашгийн бодлогын хүрээнд жил бүр ногдол ашиг зарласаар байгаа ба 2025 онд 1 тэрбум төгрөгийн үнэ бүхий хувьцааг Монголын Хөрөнгийн Биржийн нээлттэй арилжаагаар дамжуулан, эргүүлэн худалдан авсан нь шинэлэг ба хувьцааны хөрвөх чадварыг дэмжсэн чухал ажил боллоо. Мөн Монложистикс Групп (MSE:MLG) 2025 онд Монголын Хөрөнгийн Биржийн I ангилалд арилжаалагдах 25 хувьцааны нэг болон дэвшсэн нь манай засаглалын стандарт, мэдээллийн ил тод байдлын хүлээн зөвшөөрөгдсөний илрэл юм.

Хэдийгээр зах зээл, эдийн засгийн сорилттой, олон улсын геополитикийн нарийн төвөгтэй, тодорхой бус байдал үргэлжилсэн орчинд бизнесийн үйл ажиллагаа явагдаж байгаа ч Монложистикчууд бид ойрын болон урт хугацааны ирээдүйд бий болох эрсдэл ба боломжид бүрэн бэлэн гэдгийг дуулгая. Дотоод бүтээмжийн өсөлт, технологийн шинэчлэл, төслүүдийн судалгаа, шинжилгээ, хөрөнгө оруулалт татах боломжууд нь бүгд бидний урт хугацааны стратегийн бэлтгэл ажлууд ба Монгол улсын хэмжээнд хэрэгжиж байгаа дэд бүтцийн хөгжлийн бодлоготой нягт уялдаатай юм. Гашуунсухайт-Ганцмод хил холболтын ажил нь дараа дараагийн боомтуудын төмөр замын холболтын эхлэл байх ба энэ нь Монгол Улсын экспортын тээвэрт том өөрчлөлт, бүтээмжийн өсөлтийг бий болгоно. Харин Багахангай-Хөшгийн хөндий-Эмээлт чиглэлийн шинэ төмөр зам нь импортын тээвэрт маш том өөрчлөлтийг авчрах төслүүд хэрэгжиж байна.

Тэгэхлээр бид цаг зуурын, богино хугацааны сорилтууд дээр төвлөрөхөөс илүүтэйгээр урт хугацааны дэвшилтэт, үсрэнгүй хөгжлийн ажлууд дээр тууштай, сахилга баттайгаар, илүү стратегич, ухаалгаар ажиллах шаардлагатай байна.

Монложистикс Группэд үзүүлж буй тасралтгүй итгэл, дэмжлэгт тань талархал илэрхийлье. Компанийн түүхийн шинэ хуудсаа эргүүлэн, дараагийн арванаа эхлүүлж буй энэ цагт Монложистикчууд бид Монгол Улсын тээврийн салбарт үнэ цэнийг бүтээж, хувь нэмрээ оруулах итгэл үнэмшил, эрч хүчээр дүүрэн ажиллаж байна.

Хүндэтгэсэн,

Г. ХИШИГБАТ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК



ОНЦЛОХ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

ҮЗҮҮЛЭЛТ	Хэмжих нэгж	2023	2024	2025	Өсөлт (Бууралт)
ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ	мян.кг	1,042.33	1,124.65	809.25	-28%
ОРЛОГЫН ҮР ДҮН					
Борлуулалтын орлого	сая.төг	210,361	294,369	285,252	-3%
Нийт ашиг	сая.төг	18,108	21,893	21,486	-2%
Үйл ажиллагааны ашиг	сая.төг	9,290	10,206	9,974	-2%
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		8,363	10,346	9,397	-9%
БАЛАНС					
Эргэлтийн хөрөнгө	сая.төг	54,577	82,080	75,033	-9%
Эргэлтийн бус хөрөнгө	сая.төг	3,031	10,275	19,209	87%
Нийт хөрөнгө	сая.төг	57,609	92,355	94,242	2%
Нийт өр төлбөр	сая.төг	14,169	43,705	39,088	-11%
Нийт эздийн өмч	сая.төг	43,439	48,650	55,154	13%
Нийт эздийн өмч ба өр төлбөр	сая.төг	57,609	92,355	94,242	2%
МӨНГӨН ГҮЙЛГЭЭ					
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	4,480	(13,598)	6,196	-146%
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(2,390)	(14,462)	(1,614)	-89%
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	6,037	15,142	(739)	-105%
Бусад мөнгөн гүйлгээ	сая.төг	(203)	(495)	(265)	-47%
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	7,924	(13,413)	3,579	-127%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	сая.төг	14,198	22,122	8,709	-61%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	сая.төг	22,122	8,709	12,288	41%
ТАТВАР ТӨЛӨЛТ					
НӨАТ	сая.төг	3,152	9,270	10,744	16%
ААНОАТ	сая.төг	1,275	1,960	879	-55%
Гаалийн татвар	сая.төг	-	2,705	3,756	39%
Онцгой албан татвар	сая.төг	-	12,011	6,232	-48%
Нийт татвар төлөлт	сая.төг	4,427	25,946	21,610	-17%

ОНЦЛОХ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Харьцаа үзүүлэлтүүд				
Санхүүгийн харьцаа үзүүлэлт / Financial ratio		2023	2024	2025
Нийт ашгийн хувь Gross margin	хувь	8.6%	7.4%	7.5%
Цэвэр ашгийн хувь Net margin	хувь	4.0%	3.5%	3.3%
Өөрийн хөрөнгийн өгөөж Return on equity	хувь	24%	22%	18%
Өөрийн хөрөнгийн харьцаа Solvency ratio	хувь	51%	47%	46%
Үйл ажиллагааны эргэц Operation cycle	хоног	71.94	48.49	43.60
Эргэлтийн харьцаа Current ratio	нэгж	3.98	2.20	2.52
Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа Cash ratio	нэгж	3.43	1.36	1.96
Хувьцааны харьцаа үзүүлэлт Share ratio		2023	2024	2025
Нэгж хувьцаанд ногдох ашиг Earnings per share	төгрөг	14.97	18.54	17.11
Эргэлтэнд байгаа хувьцаа Number of shares issued **	ширхэг	395,858,822	395,858,822	391,990,603
Хувьцааны хаалтын ханш Share price at year-end ***	төгрөг	180.39	185.00	190.00
Зарласан нэгж хувьцаанд ногдох ашиг	төгрөг	7.58	5.40	5.80



ДЭЛХИЙ РҮҮ ТЭМҮҮЛСЭН 20 ЖИЛ

10-С ДЭ АЖИЛЛА



Монложистикс групп үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ойн баяр

2005 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр тээвэр ложистикийн салбарт нэгэн цоо шинэ тоглогч орж ирсэн нь “Монложистикс Ворлдвайд” хязгаарлагдмал хариуцлагатай компани байсан юм. Нисэж буй тагтаагаар эрүүл, аюулгүй эх дэлхийдээ бид нийгмийн хариуцлагатай байж, дэлхийн хаана ч, хэдий ч шуурхай хүрч ажиллах үйл хэрэг маань нар мэт гэрэлтэн, саадгүй байхыг бэлгэдсэн лого, “We deliver success буюу бид амжилт бүтээлийг түгээнэ” гэсэн уриа үгтэй шинэхэн байгуулагдсан компаниа “Улс тунхагласны баяр”-ын өдрөөр огноолон улсын бүртгэлийн санд бүртгүүлсэн нь их бэлгэшээлтэй. 2025 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр бол Монложистикс Группийн буюу ууган компани үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ой тохиосон онцгой өдөр байлаа.



Өнгөрсөн хорин жилийн хугацаанд бизнесийн үр ашгаас илүүтэй салбартаа шинэ соёл, ложистикийн шинэ шийдэл, менежментийн стандарт, хариуцлагын жишиг тогтоосноороо бид манлайлагчийн байр сууринд хүрч, олон нийтийн оролцоотой нээлттэй компани болжээ. Компани үүсгэн байгуулагдсан цагаас хойш тасралтгүй хорин жилийн хугацаанд идэвх зүтгэлтэй ажиллаж, компанидаа болон салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан ажилтнуудын хөдөлмөр зүтгэлийг нь өндрөөр үнэлж, төрийн дээд одон медалиар шагнагдсан бол компанийн зүгээс тогтвор суурьшилтай ажиллаж буй 28 ажилтнуудыг гадаад улсад аялах эрхээр, нийт ажилтнуудыг мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан бөгөөд ажилтан төвтэй хүний нөөцийн бодлогын хүрээнд 2 ажилтанд байрны урьдчилгаа төлбөрийн дэмжлэг үзүүлээ.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



Монложистикс Групп 50 ширхэг хөдлөх бүрэлдэхүүнтэй боллоо.

Монложистикс Групп нь бизнесийн үр ашгаа нэмэгдүүлэх, өрсөлдөөний давуу талуудыг бий болгох зорилгоор дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт хийх IPO-н төлөвлөгөөний дагуу ОХУ-аас худалдан авсан эхний ээлжийн вагонуудаа 2024 оны 12-р сард амжилттай хүлээн авсан бол дараагийн ээлжийн 40 ширхэг вагоныг 2025 оны 6-р сард хүлээж авлаа.



Тяньжин РТ Ложистикс ХХК-ийн бизнес түншлэл эхэллээ.

Тяньжин РТ Ложистикс компанийн гол зорилго нь БНХАУ-аас болон гуравдагч орнуудаас ирж буй Монгол Улсын импортын тээврийг илүү хурдан, хямд, хүртээмжтэй болгох явдал юм. Энэ зорилгынхоо хүрээнд COSCO групп болон EAS-тэй хамтын ажиллагааны гэрээ байгуулж, бизнес түншлэлийн эхний алхамуудаа амжилттай эхлүүлээд байна.



MSE:MLC хувьцаа ангилал ахилаа.

Монголын Хөрөнгийн Биржийн үнэт цаасны ангилал 2025 оны 9-р сард шинэчлэгдэж, Монложистикс Групп (MSE:MLC) нь I ангилал руу дэвшлээ. Монголын хөрөнгийн бирж дээрх хувьцаануудын арилжааны идэвх, зах зээлийн үнэлгээ, компанийнх нь засаглал, мэдээллийн ил тод байдал зэрэг олон шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан үзэж 3 ангилдаг бөгөөд MSE:MLC хувьцаа ийнхүү Монголын хөрөнгийн зах зээлд I ангилалд арилжаалагдах 25 хувьцааны нэг боллоо.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



Оюутолгойн зэсийн баяжмалыг төмөр замаар тээвэрлэх тендерт шалгарав.

Оюутолгой ХХК-аас зарласан “Зэсийн баяжмалыг төмөр замаар экспортлох тээвэрлэгчийг сонгон шалгаруулах тухай” тендерт Монложистикс Ворлдвайд ХХК оролцож, шалгарсан. 2025 оны 10 дугаар сард Цогтцэций-Зүүнбаян-Замын-Үүд-Эрээн гэсэн маршрутаар тээвэрлэлтийг эхлүүлэх төлөвлөгөөтэй байсан боловч олон хүчин зүйлийн нөлөөгөөр хараахан хэрэгжиж эхлээгүй байна.



Хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөр үргэлжилж байна.

Монложистикс Холдинг ХК (MSE:MLG)-ийн хувьцааны эрэлт нэмэгдэж, арилжааны идэвхжил сайжрах, хувьцааны үнэ тогтвортой байх, өсөх, хөрөнгө оруулалтын сонирхлыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилготой хөтөлбөрийг хэрэгжүүлж, үргэлжлэх хугацааг 2026 оны 03-р сарын 31-ний өдрийг хүртэл сунгахаар шийдвэрлэсэн.



MinePro Mongolia 2025-д оролцлоо.

Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээврийн төрөлжсөн үйлчилгээ үзүүлэгч Монложистикс Групп нь Монголын эрдэс баялгийн салбарын хамгийн том арга хэмжээ болох MinePro Mongolia 2025-д тээвэр ложистикийн цогц шийдэл, төслийн ачаа, дараа төлбөрт уян хатан тээврийн нөхцөлүүдээ танилцуулж оролцлоо.

ОНЦЛОХ ТЭЭВЭР



ХҮНД ДААЦИЙН ЧИРЭГЧ

2025 оны нэгдүгээр улиралд Оюу Толгойн гүний уурхайд хүдрийн баяжмал тээвэрлэх зориулалттай хүнд даацын чирэгч толгой болон чиргүүлийг амжилттай тээвэрлэлээ. WMRM буюу ягаан лого нь Woman in Mining and Resources Mongolia буюу уул уурхай ашигт малтмалын салбарын эмэгтэйчүүдийн холбоо бөгөөд Оюу Толгой ХХК-д тус логотой хувцас хэрэглэл, тоног төхөөрөмжөөр дэмжлэг үзүүлж ажилладаг байна.



ЦАХИЛГААН СТАНЦЫН ТРАНСМАТОР

Төв аймгийн Баянжаргалан сумын нутагт баригдсан Бөөрөлжүүтийн дулааны цахилгаан станцад суурилуулсан трансформаторыг амжилттай тээвэрлэж, хүлээлгэн өгсөн билээ. Уг ачаа нь хэт хүнд, оворихтэй, эмзэг ачаа бөгөөд тээвэрлэлтийн хурдны хязгаарлалт, доргилт мэдрэгчтэй тул тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангаж, хамгаалалтын автомашинаар дагалдуулан тээвэрлэснээрээ онцлогтой юм.



ТЭСЭЛГЭЭНИЙ МАТЕРИАЛ

2025 оны гуравдугаар улиралд томоохон ханган нийлүүлэгчийн тэсэлгээний материалыг агаараар амжилттай тээвэрлэлээ. Тэсэлгээний материалыг агаараар тээвэрлэх нь өндөр эрсдэлтэй бөгөөд тусгай горимоор, аюулгүй ажиллагааг өндөр түвшинд шаардсан онцгой тээвэр билээ.

ОНЦЛОХ ТЭЭВЭР



ХҮНД ОВРЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

MinePro Mongolia 2025 олон улсын уул уурхайн тоног төхөөрөмжийн экспод үзүүлэнгийн зориулалтаар 120 тонн даацтай овор болон жин хэтрүү "Dump Truck"-ийг тусгай нөхцөл, зохицуулалтын дагуу амжилттай тээвэрлэлээ.

Эрээн хотоос Эрдэнэт уурхайн чиглэлд 76 тонн бүхий жин хэтрүү уурхайн тоног төхөөрөмжийн сэлбэг, эд ангиудыг амжилттай тээвэрлэлээ.



УРАН ЗУРГИЙН ТЭЭВЭРЛЭЛТ

БНХАУ-ын Бээжин хотод 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс 2026 оны 02 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл зохион байгуулагдсан "Бээжингийн олон улсын дүрслэх урлагийн биенналь 2025" арга хэмжээнд Монгол Улсыг төлөөлөн 5 уран бүтээлч өөрийн бүтээлээрээ оролцсон юм. Уг үзэсгэлэнд хүргэгдсэн нийт 189 кг жинтэй, 104,088.00 ам.долларын үнэлгээ бүхий бүтээлүүдийн тээвэрлэлтийг амжилттай зохион байгууллаа.



БУЛЬДОЗЕР БОЛОН БОЙЛЕРЫН ТЭЭВЭРЛЭЛТ

2025 оны дөрөвдүгээр улиралд Ганц Мод боомтоос Гашуун Сухайт боомтын чиглэлд хүнд оврын тоног төхөөрөмжийн тээвэрлэлтийг амжилттай зохион байгууллаа. Нийт 5 ширхэг гинжит бульдозер, 1 ширхэг Zopen брэндийн үйлдвэрийн бойлерыг тус тус хүнд даацын тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл, мөн бэхлэгээ, хамгаалалтын стандарт шаардлагыг бүрэн хангаж амжилттай тээвэрлэлээ.

ЗАХ ЗЭЭЛ БА СТРАТЕГИ

Үйл ажиллагааны уян хатан байдал, стратегийн хөрөнгө оруулалт, дижитал шилжилтийг хослуулж, БНХАУ болон бусад орнуудтай стратегийн түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлуудыг эхлүүлж, тээврийн сүлжээний хамрах хүрээг тэлэх чиглэлийг баримтлан ажиллалаа.

50ш

АЧААНЫ ВАГОН ХУДАЛДАН АВЛАА

Дижитал шилжилт



ДЭЛХИЙН ТЭЭВЭР ЛОЖИСТИКИЙН САЛБАР

2025 оныг товчхон дүгнэвэл дэлхийн геополитикийн нөхцөл байдал урьдчилан таамаглахад бэрх, бүс нутгийн зөрчил хурцадмал, томоохон эдийн засагтай улс гүрнүүдийн хооронд худалдаа, хамтын ажиллагаа суларсан, тодорхойгүй байдал давамгайлсан жил байлаа. Дэлхийн худалдааны өсөлт 2025 онд ойролцоогоор 2.5–3 хувийн түвшинд хадгалагдсан нь цар тахлын дараах сэргэлтийн үеийнхтэй харьцуулахад удааширсан үзүүлэлт бөгөөд геополитикийн эрсдэл, худалдааны хязгаарлалтууд үүнд голлон нөлөөлөв.

Дэлхийн худалдаа ба тодорхойгүй байдал

2025 оны эхний хагаст АНУ-аас авч хэрэгжүүлсэн гадаад худалдааны тариф болон түүнтэй холбоотой бодлогын нөлөөгөөр худалдааны бодлогын тодорхойгүй байдлын индекс (Trade Policy Uncertainty Index) түүхэн дээд түвшинд хүрч, 2020 оны цар тахлын үеийн оргил үзүүлэлтээс ч хоёр дахин давсан хэмжээнд очсон байна. Энэхүү тодорхойгүй байдлаас үүдэж дэлхийн контейнер тээврийн эргэлтийн өсөлтийг 3–4 орчим хувиар сааруулж, тээврийн үнийн хэлбэлзлийг нэмэгдүүлж улмаар компаниуд урт хугацааны гэрээ байгуулах хандлагыг бууруулах зэрэг шууд нөлөөллийг үзүүлсэн. Үүний үр дүнд ложистикийн компаниуд богино хугацааны, уян хатан шийдвэр гаргалтад илүү төвлөрөх шаардлагатай болов.

Геополитик ба нийлүүлэлтийн сүлжээний өөрчлөлт

Түүнчлэн, 2022 онд эхэлсэн ОХУ–Украины дайны нөлөө 2025 онд улам гүнзгийрч, Ази–Европын хоорондын уламжлалт тээврийн урсгалд дараах өөрчлөлтүүдийг авчирлаа.

- Нийлүүлэлтийн сүлжээ төрөлжих (diversification)
- Тээврийн маршрут олон хувилбартай болох (route flexibility)
- Дижитал шийдэл (AI, real-time tracking) эрчимжих
- Эрсдэлийн удирдлага стратегийн түвшинд шилжих

Энэхүү хориг, хязгаарлалтуудын улмаас зарим компаниуд шинэ, алтернатив маршрутуудыг хөгжүүлэх, Multi-modal буюу хосолмол тээврийн шийдлийг нэвтрүүлэх, агуулах, нөөцийн стратегия өөрчлөх зэрэг арга хэмжээг идэвхтэй авч хэрэгжүүлэх болсон.

Энэ нь эцсийн дүндээ нийлүүлэлтийн сүлжээний найдвартай байдал буурах, санхүүгийн эрсдэл нэмэгдэх, төлбөр тооцооны саатал үүсэх зэрэг олон сөрөг үр дагаврыг бий болгов.




Үйлдвэрлэл шилжилт ба шинэ ложистикийн төвүүд

АНУ–БНХАУ-ын худалдааны харилцаа 2025 оны хоёрдугаар хагаст тодорхой хэмжээнд тогтворжсон хэдий ч компаниуд геополитикийн эрсдэлээ бууруулах зорилгоор “China Plus One (C+1)” стратегийг эрчимтэй хэрэгжүүлж эхэлсэн. Үүний үр дүнд Зүүн Өмнөд Ази руу чиглэсэн

үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт 8–12 хувиар нэмэгдэж, Энэтхэгийн үйлдвэрлэлийн салбарын экспорт 10 хувиас дээш өсөлттэй гарсны зэрэгцээ Вьетнам, Индонез, Энэтхэг зэрэг улсууд шинэ ложистикийн зангилаа болон хөгжиж байна. Энэхүү өөрчлөлт нь дэлхийн тээвэр, ложистикийн урсгалыг “Хятад төвтэй” загвараас “олон тулгуурт бүс нутгийн” загвар руу шилжих суурийг тавьлаа.

Хятадаас хөрөнгө оруулалтаа шилжүүлж буй
компаниудын гол чиглэлүүд



Салбарын бүтцийн өөрчлөлтийн жил

Ийнхүү 2025 онд тээвэр, ложистикийн салбар нь өндөр эрсдэл, тодорхойгүй байдал давамгайлсан орчинд ажилласан хэдий ч дараах хэд хэдэн томоохон бүтцийн өөрчлөлтүүд бодитоор эхэлсэн онцлог жил боллоо. Үүнд:

- Ази–Европын төмөр замын транзит тээврийн хэмжээ 20–30% буурсан;
- Тээврийн хугацаа дунджаар 15–25% уртассан;
- Ложистикийн зардал зарим чиглэлд 30–50% хүртэл өссөн;

Эдгээр өөрчлөлтүүд нь богино хугацаанд зардал нэмэгдүүлсэн ч урт хугацаанд салбарын тогтвортой байдал, уян хатан чанарыг сайжруулах суурь болж байна.

Тээвэр ложистикийн зах зээлийн хэмжээ

2025 онд дэлхийн ложистикийн зах зээлийн хэмжээ 12 их наяд орчим ам. долларт хүрч цаашид 2030 он гэхэд 18 орчим их наяд ам. доллар болж, жилд дунджаар 6–7% өсөлт үзүүлэх хүлээлттэй байна. Энэ нь тээвэр, ложистикийн салбар нь дэлхийн эдийн засгийн суурь дэд бүтэц хэвээр бөгөөд дэлхийн ДНБ-ий 10–12 хувийг бүрдүүлж байгаа нь цаашид ч чухал салбар байна гэдгийг илтгэх үзүүлэлт юм.

Өнгөрсөн онд дэлхийн худалдааны 90 орчим хувь нь (эзлэхүүнээр) далайн тээврээр, 1 хүрэхгүй хувь нь агаарын тээврээр тээвэрлэгдсэн боловч үнэлгээгээр 35 хувьтай тэнцэх үзүүлэлт байлаа. Харин төмөр замаар, ялангуяа Евразийн чиглэлд нийт ачаа тээврийн 7 орчим хувь нь тээвэрлэгдсэн байна. Гэвч 2024 онд 185 сая TEU-д хүрсэн контейнер тээврийн хувьд 2025 онд 190 сая гаруй TEU болж өссөн нь хүлээлтээс харьцангуй доогуур үзүүлэлт байв. Үүнээс гадна дэлхийн томоохон 10 боомт нийт контейнер эргэлтийн 50 гаруй хувийг эзэлж байгаагийн дотор Шанхай, Тяньжин, Сингапур зэрэг хотуудын боомтууд байгаа нь дэлхийн контейнер тээврийн урсгал Азид төвтэй хэвээр байлаа.

Агаарын тээврийн хувьд 2025 онд 70 сая орчим тоннд хүрсэн нь бусад тээврийн төрлүүдээс харьцангуй өндөр үзүүлэлт юм. Үүний хамгийн гол шалтгаан нь e-commerce буюу цахим худалдааны салбарын өсөлт жилд 5 орчим хувь байгаа нь салбарын томоохон тоглогчид болох FedEx, UPS, DHL зэрэг компаниудын ашигт ажиллагаа нэмэгдэх түлхэц болов. Дэлхийн тээвэр ложистикийн өртөг компаниудын нийт зардлын 8–12 хувийг эзлэх болсон нь цар тахлын үеэс даруй 20–40 хувь өссөн үзүүлэлт юм. Үүн дээр нэмээд дижитал ложистикийн зах зээл 2025 онд 25 орчим тэрбум ам.долларт хүрсэн нь хиймэл оюун болон IoT ашиглалт хурдацтай нэмэгдэж, дэлхийн тээвэр ложистикийн компаниудын 50 гаруй хувь нь үйл ажиллагаандаа нэвтрүүлж эхэлсэнтэй холбож тайлбарлаж болохоор байлаа.

МОНГОЛ УЛСЫН ТЭЭВЭР ЛОЖИСТИКИЙН САЛБАР

2025 онд Монгол Улсын тээврийн салбарын нийт тээвэрлэсэн ачааны хэмжээ 146.5 сая тоннд хүрч, өмнөх оноос 9 хувиар өссөн эерэг үзүүлэлттэй гарсан. Гэсэн хэдий ч салбарын нийт орлого 9.3 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 9 хувиар буурсан нь ачаа эргэлт өссөн ч орлогын өгөөж буурсныг илтгэж байна. Энэхүү зөрүү нь:


- Тээврийн зах зээлд үнийн өрсөлдөөн эрчимжсэн
- Экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрсний үнэ буурснаас нэгж тээврийн орлого багассан
- Мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр дотоодын хэрэглээ болон импортын урсгал саарсан зэрэг үндсэн шалтгаантай.

2026 оны хүлээлт

2026 онд тээврийн салбарын орлого 11.2 их наяд хүрч, салбар 18 хувиар өсөх хүлээлттэй байна. Гэхдээ энэхүү хүлээлт нь гадаад зах зээлийн нөхцөл байдал болон макро эдийн засгийн бодлогоос үлэмж хамааралтай. Дээрх өсөлтийг дэмжих гол хүчин зүйлс нь:

- Зэсийн олборлолт болон зах зээлийн үнэ өсөх
- Нүүрсний үнэ тогтворжиж, цаашид өсөх
- Хилийн боомтуудын нэвтрүүлэх чадвар сайжрах
- Томоохон бүтээн байгуулалтын төслүүдтэй холбоотой импортын тээвэр нэмэгдэх
- Транзит тээврийн ачаа нэмэгдэх зэрэг байх нь гарцаагүй юм.

Экспорт, импортын бүтэц 2025 он (дүнд эзлэх хувиар)



2025 онд Монгол Улсын нийт экспортын 85 орчим хувийг уул уурхайн гаралтай бүтээгдэхүүн, үнэт металын түүхий эд дангаар эзэлж байгаа бол импортын дийлэнх буюу 60 шахам хувийг машин, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн эд анги болон нефтийн бүтээгдэхүүн эзэлж байна.

МОНЛОЖИСТИКС ГРУПП

Дээрх зах зээлийн тодорхойгүй, эрсдэлтэй орчинд Монложистикс Групп нь үйл ажиллагааны уян хатан байдал, стратегийн хөрөнгө оруулалт, дижитал шилжилтийг хослуулсан бодлого баримталж ажилласан нь 2025 оны онцлог байлаа. Группийн хувьд зах зээлийн эдгээр өөрчлөлт, нийлүүлэлтийн сүлжээний саатал, тээврийн зардлын өсөлт зэрэг сорилтуудыг боломж болгон ашиглахаас гадна экспортын тээврийн чиглэлд үйл ажиллагаагаа урт хугацаанд тогтвортой байлгах, төрөөс баримталж байгаа бодлого, шийдвэртэй нийцүүлэн томоохон хөрөнгө оруулалтыг хийж, шинэ маршрут хөгжүүлэх, гадаад зах зээлд үйл ажиллагаагаа тэлэх стратегийг идэвхтэй хэрэгжүүлэв. Тухайлбал, төмөр замын тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалтыг амжилттай хэрэгжүүлж, ОХУ-аас шинээр 50 ачааны хагас вагон үйлдвэрлүүлж худалдан авсан нь группийн хувьд зөвхөн импортын хамааралтай бүтэцтэй бизнесээс экспортод чиглэсэн, илүү өндөр өгөөжтэй сегмент рүү анхаарсан стратегийн чухал алхам болсон. Мөн дижитал шилжилтийн хүрээнд үйл ажиллагаандаа хиймэл оюунд

суурилсан шийдлүүдийг нэвтрүүлж, харилцагчийн үйлчилгээ, мэдээллийн урсгал, дотоод процессуудыг оновчлох чиглэлд ахиц гаргасан нь үйл ажиллагааны үр ашиг, шийдвэр гаргалтын хурдыг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлээ. Хэдийгээр олон улсын зах зээл тогтворгүй нөхцөл байдалтай байсан ч бүс нутгийн тээвэр ложистикийн салбарт өөрсдийн байр сууриа бэхжүүлэх, тэр дундаа БНХАУ болон бусад орнуудтай стратегийн түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлуудыг эхлүүлж, тээврийн сүлжээний хамрах хүрээг тэлэх чиглэлийг баримтлан ажилласан нь ирээдүйн тогтвортой өсөлтийн суурийг тавьж чадсан үйл явдал байв.

Ийнхүү 2025 онд Монложистикс Групп нь зах зээлийн тийм ч таатай биш нөхцөлд эрсдэлийг удирдах, боломжийг ашиглах, стратегийн чиглэлээ оновчтой тодорхойлоход тодорхой ахиц гарган ажиллаж цаашид экспортын тээврийг нэмэгдүүлэх, бүрэн дижитал үйл ажиллагааг нэвтрүүлсэн тээвэр, ложистикийн компани болох, бүс нутгийн интеграцид идэвхтэй оролцох зорилтыг хэрэгжүүлэх суурь бүрдсэн жил боллоо.



АЛСЫН ХАРАА 2030

Бид орчин үеийн дэд бүтэц, үйлчилгээний чанар дээр суурилсан цогц ложистик үйлчилгээг нэвтрүүлж улмаар Монгол Улсыг Ази, Европыг холбосон ложистик төв болгоно. Уг алсын харааг биелүүлэх урт хугацааны стратеги, зорилгын хүрээнд дараах ажлыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.




2030 СТРАТЕГИ

Монложистикс Групп нь өсөлтийн 4 стратеги, тогтвортой хөгжлийн 4 стратегийг хэрэгжүүлэн ажиллаж байна.



БИЗНЕС МОДЕЛЬ

Олон улсад нийлүүлэлтийн сүлжээг удирдах хэлбэр 1PL загвараас 5PL хүртэл хөгжөөд буй бөгөөд Монложистикс Группийн хувьд өөрийн харилцагч байгууллагуудын ачааг тээвэрлэх тээврийн шинэ маршрутыг хөгжүүлснээр геополитикийн хүндрэлээс үүсэж буй тээвэрлэлтийн хүндрэл бэрхшээлийг даван туулах, хамтран ажиллагч түншийн харилцаа болон дэд бүтцийн ашиглалтыг нэмэгдүүлснээр тээвэрлэлтийн хямд бөгөөд хурдан шуурхай үйлчилгээг санал болгож, өөрийн 3PL бизнес моделийг хөгжүүлэн ажиллаж байна.



3PL загвар нь ханган нийлүүлэлтийн гинжин хэлхээний олон асуудлыг хариуцдаг мэргэжлийн ложистикийн үйлчилгээ үзүүлэгч компаниас Ачааг хүлээн авах, Тээвэрлэх, Хадгалах, Савлах, Шошголох, Хүргэлт хийх гэх мэт үйлчилгээг авч байгаа хэлбэр юм. 3PL үйлчилгээ үзүүлэгчид нь илгээгч болон тээвэрлэгчдийн хооронд зохион байгуулагчийн үүрэг гүйцэтгэж, үр ашгийг оновчтой болгох, зардлыг бууруулах, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхийн тулд нийлүүлэлтийн гинжин хэлхээний ложистикийг удирддаг. 3PL үйлчилгээ үзүүлэгч компаниудын үйлчилгээг ашигласнаар бизнес эрхлэгчид үндсэн бизнестээ анхаарлаа төвлөрүүлж, ложистикийн хэрэгцээгээ туршлагатай мэргэжилтнүүдэд даатгаж чаддаг.

Бидний хувьд ачаа илгээгчээс хүрэх эцсийн цэг буюу ачаа хүлээн авагчид очих хүртэл тээвэр, ложистикийн бүхий л үйлчилгээг харилцагчдадаа санал болгодог. Үүнд тээврийн захиалга хүлээн авах, ачаа барааг илгээгчээс хүлээн авахаас өгсүүлээд агуулахын үйлчилгээ, баримт бичиг гаалийн бүрдүүлэлт хийх, ачааг тээврийн хэрэгсэлд ачих, бэхлэх, нэг тээврийн хэрэгслээс нөгөөд шуурхай шилжүүлэн ачих гэх мэт цогц үйлчилгээ багтдаг. Түүнчлэн олон улсад тээвэр ложистикийн үйл ажиллагаа эрхэлдэг нэр хүндтэй, туршлагатай түншүүдтэй хамтран эдгээр цогц үйлчилгээг үзүүлэхийн зэрэгцээ бүх ачааг эрсдэлээс хамгаалж, даатгалд хамруулдаг нь бидний давуу тал, онцлог юм.

Тээврийн цогц үйлчилгээ

Тээврийн захиалга авах – Ачаа барааг хүлээн авах – Агуулахад хадгалах – Баримт бичиг болон гаалийн бүрдүүлэлт хийх – Ачаа барааг бэхлэх – Худалдан авалтын менежмент – Тээврийн хэрэгсэл хооронд шуурхай шилжүүлэн ачих – Даатгал

A
Ачаа
илгээгч



Эхний цэгээс эцсийн цэг хүртэлх ложистикийн цогц үйлчилгээ

Бид дэлхий даяар үйл ажиллагаа явуулж буй олон улс дах түншүүдтэйгээ хамтран ачаа илгээгчээс ачаа хүлээн авагч хүртэлх тээврийн өргөн сонголт бүхий цогц үйлчилгээг үзүүлдэг. Мөн бид өөрсдийн үйлчилгээний байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөлд анхаарлаа хандуулахын зэрэгцээ үйл ажиллагааны оновчтой байдлыг чухалчилдаг.



Тээвэрлэгчийн гэрээт
туслан гүйцэтгэгч



B
Ачаа хүлээн
авагч



Ложистикс болон түгээлтийн үйлчилгээ

Агуулахад хадгалах — Боож, баглах — Шилжүүлэн ачих — Хаягжуулалт, угсралт, шалгалтыг хийж гүйцэтгэх — Гаалийн бүрдүүлэлт — Баримт бичиг — Нийлүүлэлтийн гинжин хэлхээг оновчтой зохион байгуулах — 4PL

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Нэгтгэсэн орлогын тайлан

Орлогын тайлангийн үзүүлэлт (сая.төг)	2023	2024	2025	Өсөлт (Бууралт)
Борлуулалтын орлого	210,361	294,369	285,252	-3%
Борлуулалтын өртөг	(192,253)	(272,477)	(263,766)	
Нийт ашиг	18,108	21,893	24,486	-2%
Борлуулалт, Удирдлагын зардал	(8,482)	(11,191)	(13,168)	18%
Бусад орлого (зардал)	(35)	(496)	1,655	
Үйл ажиллагааны цэвэр ашиг	9,591	10,206	9,974	-2%
Санхүүгийн орлого (зардал)	283	1,740	(1,836)	
Татварын өмнөх цэвэр ашиг (ЕВТ)	9,874	11,946	11,810	-1%
ОАТ-н зардал	(1,222)	(1,600)	(1,788)	
Цэвэр ашиг	8,652	10,346	9,397	-9%

Орлогын тайлан

Монгол Улсын тээврийн салбар 2025 онд ачааны хэмжээгээр 9.3%-аар өсөж 146 сая.тн хүрсэн ч салбарын орлого 10.7%-аар агшиж 8.5 их наяд төгрөг болж буурав.

Монгол Улсын ДНБ-ий өсөлтөд худалдаа болон тээврийн салбарууд буурсан үзүүлэлттэй гарсны гол шалтгаан нь уул уурхайн голлох түүхий эд болох нүүрсний үнэ гадаад зах зээлд буурсан хэвээр байснаас гадна АНУ олон улсын худалдаанд тарифын хатуу бодлого хэрэгжүүлснээр дэлхийн эдийн засагт тодорхойгүй нөхцөл байдал үүсгэсэнтэй шууд холбоотой байлаа.

Монложистикс Группийн хувьд 2025 оны эхний хагас хүлээлтийн дагуу байсан хэдий ч дээр дурдсан гадаад нөхцөл байдлын нөлөө оны хоёрдугаар хагаст илэрснээс гадна дотоодод Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монгол банкнаас авч хэрэгжүүлсэн мөнгөний хатуу бодлого нь иргэдийн худалдан авах чадварт шууд нөлөө үзүүлж, худалдааны салбарыг агшаахад хүргэв. Мөн 2025 оны 6 дугаар сараас эхлэн 10 жилээс дээш насжилттай автомашинд Улаанбаатар хотын дугаар олгохгүй болсноос үүдэн Монгол Улсын импортын ачааны хамгийн том нэр төрөл болох автомашины импортын хэмжээ сүүлийн 10 жилд анх удаа буурсан нь салбарын орлого бүхэлдээ буурах томоохон хүчин зүйл болов.

Тээврийн тоо хэмжээ: (сегмент бүрээр)

Тээврийн тоо хэмжээ (мян.тн)	2023	2024	2025	эзлэх хувь	Өсөлт (Бууралт)
Импорт	90.3	91.6	79.8	10%	-13%
Экспорт	157.3	168.6	35.0	4%	-79%
Транзит	768	827.8	649.0	80%	-22%
Бусад	26.7	36.6	45.5	6%	24%
Нийт	1,042.3	1,124.7	809.3	100%	-28%

Борлуулалтын орлогын бүтэц

Монложистикс Группийн орлого нь дараах 3 хэсгээс бүрддэг.

Тээврийн үнэ: 2024 оноос тээврийн үнэ тогтворжиж, тээврийн хугацаа буурах нөхцөл байдал 2025 онд ч үргэлжиллээ. 2025 онд үүссэн АНУ-ын тарифын нөлөө болон түлшний хомсдол нь тээврийн өртөг нэмэгдэх хүлээлтийг бий болгов.

Ханш: 2025 оны ам.долларын ханш оны эхнээс 4.9% өссөн, мөн түүнчлэн дундаж ханш 3533₮ байсан нь группийн таамаглаж байсан хэмжээнээс бага байна.

Тээврийн хэмжээ: Тээврийн хэмжээ өнгөрсөн оноос 28%-иар буурсан байна. УБТЗ нь 2025 оноос эзэмшлийн бус түрээсийн вагоноор тээвэр явуулах боломжгүй болсноор экспортын тээврийн хэмжээ 79%-иар буурахад нөлөө үзүүлсэн байна. ОХУ болон Хятад улсын худалдааны эргэлт сүүлийн 5 жилд анх удаа бууралт үзүүлээ. Энэ нь Монложистикс Группийн транзит тээврийн хэмжээг 22%-иар буурахад нөлөө үзүүлээ.

Борлуулалтын орлого: (сегмент бүрээр)

Борлуулалтын орлого (сая.төг)	2023	2024	2025	эзлэх хувь
Импорт	84,286	165,995	174,924	57%
Экспорт	24,638	26,216	4,314	1%
Транзит	87,942	95,648	99,389	32%
Бусад	18,046	18,514	27,284	9%
Нийт	214,912	306,373	305,910	100%
Тохируулах бичилт	(4,551)	(12,003)	(20,658)	
Нийт	210,361	294,369	285,252	100%

Нийт ашгийн маржин хүснэгт: Тээврийн салбарт үнийн өрсөлдөөн нэмэгдэж ачаа тээврийн үнэ буурах нөлөө нь нийт ашгийн маржин буурахад нөлөө үзүүлсэн байна. Монложистикс группийн худалдан авсан вагон 2025 оны 7 сараас үйл ажиллагаанд орж эхэлж, түрээсийн вагоныг буцаахтай холбоотой зардал зэрэг нь экспортын сегментийн нийт ашгийн хувийг хасах гарахад нөлөө үзүүлсэн байна.

Нийт ашгийн маржин	2023	2024	2025
Импорт	9.6%	8.0%	6.7%
Экспорт	6.8%	6.5%	-5.7%
Транзит	7.5%	7.8%	6.1%
Бусад	9.9%	5.3%	3.7%
Нийт	8.6%	7.4%	7.5%

Цэвэр ашиг: 2025 онд группийн цэвэр ашиг 9.4 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 9% бууралттай байна. Энэ нь Cheerah брендийг зогсоосон буюу зогсоосон үйл ажиллагааны ашиг алдагдал болох 624 сая алдагдал, 2025 онд группийн 20 жилийн ойн баяртай холбоотой 1 удаагийн зардалтай холбоотойгоор бууралт үүссэн байна.

Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөнгөн гүйлгээний тайлангийн үзүүлэлт (сая.₮)	2023	2024	2025
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,480	(13,598)	6,196
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,390)	(14,462)	(1,614)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	6,037	15,142	739
Валютын ханшийн зөрүү	(203)	(495)	(265)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	7,924	(13,413)	3579
МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	14,198	22,122	8,709
МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	22,122	8,709	12,288

- Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ 6.2 тэрбум төгрөг байна. Урьдчилж төлсөн зардал, бараа материалын бууралт нь өмнөх оноос эрс өсөхөд нөлөө үзүүлсэн байна.
- Вагоны хөрөнгө оруулалтын сүүлийн төлбөр гарснаар 2025 онд хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээний нийт дүн -1.6 тэрбум төгрөг байна.
- 2025 онд санхүүжилтийн мөнгөн гүйлгээ -0.7 тэрбум төгрөг байна.
- Монложистикс группийн 2025 онд цэвэр мөнгөн гүйлгээ 3.5 тэрбум төгрөг буюу группийн Cash ratio 1.96 болж өмнөх оноос өссөн байна.

ИМПОРТЫН ТЭЭВЭР

Орлого үр дүнгийн тайлан (сая.төг)	2023	2024	2025	Өсөлт (Бууралт)
Тээврийн тоо хэмжээ	90.32 мян.тн	91.62 мян.тн	79.80 мян.тн	-13%
Борлуулалтын орлого	84,286	165,995	174,924	5%
Борлуулалтын өртөг	(76,197)	(152,704)	(163,211)	
Нийт ашиг	8,089	13,290	11,713	-12%
Нийт ашгийн хувь	9.6%	8.0%	6.7%	
Борлуулалт, ерөнхий удирдлагын зардал	(4,764)	(6,919)	(6,757)	
Бусад орлого (зардал)	(99)	(1,349)	(1,523)	
Татварын өмнөх ашиг	3,226	5,023	6,479	29%
Татварын зардал	(400)	(578)	(641)	
Цэвэр ашиг	2,826	4,446	5,838	31%
Цэвэр ашгийн хувь	3.4%	2.7%	3.3%	

Зах зээлийн нөхцөл байдал

2025 онд Монгол Улс гадаад улсаас 11.3 тэрбум ам.долларын үнэ бүхий бараа, бүтээгдэхүүн импортолсон нь өмнөх оны мөн үеэс 2%-аар буурсан үзүүлэлт юм. Үүнд голчлон тээврийн хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг, дагалдах эд ангийн импортын тоо хэмжээний бууралт томоохон нөлөө үзүүлснийг онцлох нь зүйтэй. Тухайлбал, импортын ачааны томоохон хэсгийг бүрдүүлж байдаг суудлын автомашины импорт 2024 онд 122,996 ширхэг байсан бол 2025 онд 90,345 ширхэг болж 26.5%-аар буурсан байна. Энэхүү бууралтыг автомашины насжилттай холбогдуулан төрийн эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлж буй бодлогын хүрээнд Япон улсаас импортлогдож орж ирдэг хуучин машины импорт шууд буурсантай холбож тайлбарлаж болно. Мөн хэрэглэгчдийн худалдан авах чадвар буурсантай холбоотойгоор өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний импортын тоо хэмжээ ч үүнийг даган агшсан бол нэрлэсэн дүнгээр харьцангуй тогтвортой байдал ажиглагдлаа. Нөгөөтэйгүүр, эдгээр импортын бараа бүтээгдэхүүний бууралттай холбоотой Тяньжин боомтын ачаалал, төмөр замын хүлээлгийн хугацаа хэвийн байв.

Үйл ажиллагааны товч мэдээлэл

Монложистикс Группийн охин компани болох суудлын автомашины импортын тээврийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг “Төв Азийн Зам” ХХК-ийн хувьцаа эзэмшигчээр Намир Групп ХХК орж ирсэн нь групп хоорондын хамтын ажиллагаа эхэлж, үйл ажиллагааны синержи үүсгэх, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх зэрэг томоохон шинэчлэлт, өөрчлөлтийг бий болгов. Үүнтэй нийцүүлэн, Монложистикс Групп нь 2025 онд дотооддоо байгууллагын бүтцийн шинэчлэлийг хэрэгжүүлж, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор импортын тээврийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг охин компаниудын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаанд шат дараалсан шинэчлэл хийж эхлүүлээ.

2025 оны үр дүн

2025 онд Монложистикс Группийн хувьд импортын тээврийн хэмжээ 13%-аар, нийт ашиг 12%-аар тус тус буурсан ч цэвэр ашиг 31%-аар өссөн байна. Үүнд үйл ажиллагааны зардлын хэмнэлт болон бусад орлогын өсөлт голлох нөлөөг үзүүлээ.

2026 оны хүлээлт

2026 онд Монгол Улсын импортын тээврийн зах зээлд дараах өөрчлөлтүүд гарах хүлээлтүүд байна. Үүнд:

- Ам.долларын ханш, шатахууны үнэ зэргээс шууд хамаардаг тээврийн өртөг өсөх, үүнийг дагаад тээврийн үнэ нэмэгдэх;
- МУЗГ болон нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих томоохон төслүүдийн бүтээн байгуулалттай холбоотойгоор ачаа тээврийн хэмжээ нэмэгдэх;
- Багахангай болон Хөшигийн хөндий хооронд баригдаж буй төмөр зам ашиглалтад орсноор импортын ачаа урсгал Хөшигийн хөндийн терминалд төвлөрөх
- Импортын автомашины улсын дугаар олголтын хязгаарлалттай холбогдуулан автомашины импорт үргэлжлэн буурах;

Группийн хэмжээнд дээрх хүлээлтүүдэд үндэслэн зах зээлийн байр сууриа нэмэгдүүлэх зорилгоор урт хугацааны хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байна.

ЭКСПОРТЫН ТЭЭВЭР

Орлого үр дүнгийн тайлан (сая.төг)	2023	2024	2025	Өсөлт (Бууралт)
Тээврийн тоо хэмжээ	157.32 мян.тн	168.56 мян.тн	35.00 мян.тн	-79%
Борлуулалтын орлого	24,638	26,216	4,314	-84%
Борлуулалтын өртөг	(22,965)	(24,514)	(4561)	
Нийт ашиг	1,673	1,702	(247)	-115%
Нийт ашгийн хувь	6.8%	6.5%	-5.7%	
Борлуулалт, ерөнхий удирдлагын зардал	(411)	(475)	(507)	
Бусад орлого (зардал)	(154)	(203)	(236)	
Татварын өмнөх ашиг	1,108	1,024	(990)	-197%
Татварын зардал	(133)	(127)	85	
Цэвэр ашиг	976	897	(904)	-201%
Цэвэр ашгийн хувь	4.0%	3.4%	-21%	

Зах зээлийн нөхцөл байдал

2025 оны байдлаар Монгол Улсын экспортын хэмжээ өмнөх оны түүхэн дээд түвшнээс бага зэрэг буурч, ойролцоогоор 80–82 сая.тн бүтээгдэхүүн экспортод гаргасан нь 2024 онтой харьцуулахад 3–5 хувиар буурсан үзүүлэлт боллоо. Үүнд нүүрсний экспорт 70–72 сая.тн, төмрийн хүдэр 6.0–6.5 сая.тн болж буурсан бол, зэсийн баяжмал 2.2–2.4 сая.тн, жонш 1.3 сая.тн орчимд хүрч өссөн, харин цайрын экспорт 0.3–0.35 сая.тн түвшинд тогтвортой хадгалагдсан байна. БНХАУ-ын нүүрсний импортод Монгол Улсын эзлэх хувь өмнөх оны өндөр түвшнээс бага зэрэг буурсан. Түүнчлэн УБТЗ ХНН-ийн зүгээс гол замын ачааллыг бууруулах, тээврийн үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд түрээсийн вагонуудыг буцаах үйл ажиллагааг үргэлжлүүлснээр хувийн эзэмшлийн вагоны тээврийн хэмжээ нэмэгдэж, төмөр замын тээврийн бүтэц илүү зах зээлд суурилсан, уян хатан хэлбэрт шилжих нөхцөл бүрдсэн.

Үйл ажиллагааны товч мэдээлэл

Монложистикс Групп нь IPO-ийн төлөвлөгөөний хүрээнд экспортын тээврийн үйл ажиллагаанд шаардлагатай төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнд хөрөнгө оруулалт хийж, өөрийн эзэмшлийн нэг цуваа буюу 50 ачааны хагас вагоныг 2025 оны 2-р хагасаас эхлэн экспортын тээвэрт оролцуулж эхэллээ. Мөн Оюутолгой ХХК-ийн зэсийн баяжмалыг төмөр замаар тээвэрлэх сонгон шалгаруулалтанд амжилттай шалгарч тээврийг эхлүүлэхээр бэлтгэл ажлаа хангаад байна.

2025 оны үр дүн

Дээр дурдагдсан гадаад хүчин зүйлсийн улмаас Монложистикс Группийн экспортын ачааны хэмжээ 2025 онд 35 мян.тн болж буурсан нь өмнөх онтой харьцуулахад 79%-аар буурсан үзүүлэлт боллоо. Улмаар тээврийн тоо багассанаар экспортын сегментэд үйл ажиллагаа явуулдаг компаниудын борлуулалтын орлого болон ашгийн түвшинд шууд нөлөө үзүүлэв. Хэдийгээр экспортын тээврийн зах зээл уул уурхайн бүтээгдэхүүний үнэ болон эрэлтээс хамаарч хэлбэлзэж байдаг боловч бидний хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төслүүд, өөрсдийн эзэмшлийн вагон худалдаж авсан зэрэг нь урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаагаа явуулах үндэс боллоо гэж дүгнэж байна.

2026 оны хүлээлт

Монгол Улсын экспортын хэмжээ 2026 онд 83–85 сая.тн орчимд хүрэх төсөөлөлтэй байгаа бөгөөд 2024 оны дээд үзүүлэлттэй харьцуулахад тогтворжилтын шатанд шилжиж байна. Экспортын бүтцэд нүүрс давамгай хэвээр байгаа ч өсөлтийн хурд саарч, нийт нүүрсний экспорт 70–73 сая.тн түвшинд хадгалагдах төлөвтэй байна. Үүний зэрэгцээ Оюутолгойн гүний уурхайн олборлолт 2025 оноос эрчимжиж, 2026 онд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн гарц нэмэгдэж эхэлснээр зэсийн баяжмалын экспорт 2.5–2.7 сая.тн орчимд хүрэх хандлагатай байна. Ингэснээр экспортын бүтэц тодорхой хэмжээнд төрөлжиж, уул уурхайн бусад бүтээгдэхүүний эзлэх хувь бага боловч нэмэгдэх хүлээлт байна. Ложистикийн хувьд төмөр замын тээврийн үр ашиг өмнөх онуудаас сайжирч байгаа хэдий ч хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадал, ялангуяа Замын-Үүд – Эрээн чиглэлд үе үе ачаалал нэмэгдэх байдал бүрэн шийдэгдээгүй хэвээр байна. Энэ нөхцөлд Монложистикс Групп нь зах зээлийн өөрчлөлтөд нийцүүлэн хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтыг оновчлох, урт хугацааны тээврийн гэрээний багцыг нэмэгдүүлэх, мөн транзит болон экспортын урсгалд суурилсан үйл ажиллагаагаа өргөжүүлэх замаар өрсөлдөх чадвараа хадгалах, нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байна.

ТРАНЗИТ ТЭЭВЭР

Орлого үр дүнгийн тайлан (сая.төг)	2023	2024	2025	Өсөлт (Бууралт)
Тээврийн тоо хэмжээ	767.96 мян.тн	827.82 мян.тн	649.00 мян.тн	-22%
Борлуулалтын орлого	87,942	95,648	99,389	4%
Борлуулалтын өртөг	(81,353)	(88,166)	(93,374)	
Нийт ашиг	6,588	7,481	6,015	-20%
Нийт ашгийн хувь	7.5%	7.8%	6.1%	
Борлуулалт, ерөнхий удирдлагын зардал	(1,476)	(1,671)	(2,158)	
Бусад орлого (зардал)	185	(90)	2,237	
Татварын өмнөх ашиг	5,297	5,720	6,094	7%
Татварын зардал	(532)	(573)	(380)	
Цэвэр ашиг	4,765	5,147	5,714	11%
Цэвэр ашгийн хувь	5.4%	5.4%	5.7%	

Зах зээлийн нөхцөл байдал

2025 оны байдлаар Монгол Улсын нутгаар дамжин өнгөрөх транзит ачаа тээврийн хэмжээ өсөлтийн чиг хандлагаа хадгалж, ойролцоогоор 5.9 сая тонн хүрсэн нь өмнөх оноос 12 хувийн өсөлттэй үзүүлэлттэй байна. Транзит тээврийн суурь өртөг Швейцар франк (CHF)-аар тооцогддог бөгөөд 2025 онд ам.долларын ханш CHF-ийн эсрэг сулрах хандлагатай байсан нь тээврийн зардлыг ам.доллараар илэрхийлэхэд өсөх нөлөө үзүүлсэн байна.

Монголын нутгаар дамжин өнгөрөх тээврийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор Улаанбаатар төмөр замын гол зам дагуух өртөө, зөрлөгүүд дээр вагон бөөгнөрөх үзэгдэл 2025 онд мөн ажиглагдсан бөгөөд тодорхой үед 3,000 – 4,000 орчим чингэлэг саатсан байдал үүссэн байна. Энэхүү нөхцөл байдал нь голчлон Эрээн өртөө болон Замын-Үүд өртөөний хүлээн авах хүчин чадал хязгаартаа хүрсэнтэй холбоотой бөгөөд өртөөний зам дүүрэлт өндөр хэвээр байснаас нэмэлт ачаа хүлээн авах боломж хязгаарлагдсан байна. Үүний улмаас Замын-Үүд боомт орчимд транзит тээврийн саатал, түгжрэл үе үе үүссэн хэвээр байна.

Төлбөр тооцооны хувьд Орос-Украины дайнтай холбоотойгоор барууны орнуудын тавьсан эдийн засгийн хориг арга хэмжээ 2025 онд үргэлжилж, ОХУ-ын зарим томоохон банкууд SWIFT системээс хасагдсан хэвээр байна. Үүний улмаас олон улсын банк хоорондын гүйлгээ хийхэд хүндрэл үүсч, төлбөрийн шилжүүлгийн хугацаа уртасах, нэмэлт зуучлалын зардал бий болох зэрэг хүндрэлүүд хадгалагдсан байна.

Үйл ажиллагааны товч мэдээлэл

2025 онд Монгол улс төмөр замын транзит тээвэр нийт 5.9 сая.тн ачааг тээвэрлэж гүйцэтгэснээс Монложистикс групп нь 649 мян.тн буюу зах зээлийн 11%-ийг эзэлж байна. Энэ нь чингэлэг транзит тээврийн 16.3%-ийг эзэлж байна.

2025 оны үр дүн

Транзит тээвэр нь CNY, USD, CHF болон RUB зэрэг олон валют хооронд хийгдэж, олон улсын хориг болон төлбөр тооцоо шилжүүлэх хязгаарлалт зэрэг олон тодорхойгүй нөхцөл явагддаг хэдий ч Группийн зүгээс тодорхой авж хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд борлуулалтын орлого 4%-иар, цэвэр ашиг 11%-иар тус тус өсөөд байна.

2026 оны хүлээлт

ОХУ болон БНХАУ-ын худалдааны эргэлт ойрын жилүүдэд буурах хандлага ажиглагдахгүй байгаа ч хоёр улс санхүүгийн төлбөр тооцоо гүйцэтгэх, олон улсын гүйлгээ хийхэд хүндрэлтэй нөхцөл байдал хэвээр байсаар байна. Үүн дээр нэмээд дотоодод УБТЗ ХНН-ийн транзит ачаанд үзүүлдэг хэмжээний хөнгөлөлт (volume discount) 2026 онд цуцлагдах асуудал хэлэлцэгдэж байгаагаас гадна түлш шатахууны үнийн өсөлтөөс шалтгаалан их хэмжээний ачаа эргэлт автозамаас төмөр зам руу шилжиж, энэ хэрээр тээврийн үнэ нэмэгдэх хүлээлт үүслээ. Иймд, группийн хэмжээнд томоохон харилцагчидтай байгуулсан хамтын ажиллагааг хэвээр хадгалах, цаашид шинэ харилцагчдын тоог нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

БУСАД ТЭЭВЭР

Орлого үр дүнгийн тайлан (сая.төг)	2023	2024	2025
Тээврийн тоо хэмжээ	26.73 мян.тн	36.65 мян.тн	45.50 мян.тн
Борлуулалтын орлого	18,046	18,514	27,284
Борлуулалтын өртөг	(16,267)	(16,596)	(19,419)
Нийт ашиг	1,778	1,919	7,865
Нийт ашгийн хувь	9.9%	10.4%	28.8%
Борлуулалт, ерөнхий удирдлагын зардал	(719)	(784)	(7,642)
Бусад орлого (зардал)	(261)	(405)	1,798
Татварын өмнөх ашиг	798	730	2,022
Татварын зардал	(145)	253	(1,021)
Цэвэр ашиг	654	983	1,001
Цэвэр ашгийн хувь	3.6%	5.3%	3.7%

Зах зээлийн нөхцөл байдал

2025 онд Монгол улсын авто замаар тээвэрлэгдсэн ачааны тоо хэмжээ 96.5 сая тоннд хүрсэн нь өмнөх жилээс 10 хувийн өсөлтийг үзүүлсэн байна. Ачаа эргэлтээр авч үзвэл 14,255 сая тонн километр хүрч 7 хувийн өсөлтийг үзүүлсэн байна. Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу нийслэлийн төвлөрлийг сааруулах, бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах зорилгоор Хүннү дагуул хотыг байгуулах болсонтой холбоотой 2025 онд Улаанбаатарт хотод логистикийн дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалт хийгдээгүй. Терминалуудын хүлээн авах хүчин нэмэгдээгүй хэдий ч, хуучин машины импортын буурсантай холбоотой ачаа тээврийн дотоод үйлчилгээ бөглөрлийн асуудал ноцтой түвшинд хүрэлгүй 2025 оныг дуусгаж чадлаа.

Үйл ажиллагааны товч мэдээлэл

Монложистикс групп нь хот хоорондын тээврийг хөгжүүлэх зорилгоор өөрийн автобаазын шинэчлэл болон IT системийн хөгжүүлэлтийг хийж ажиллалаа. Мөн, Улаанбаатар хотод агуулахын үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх, Ханбогд чиглэлд түүвэр ачааг зохион байгуулах үйл ажиллагааг хөгжүүлснээс гадна чингэлэгийн талбайн үйл ажиллагаагаа тогтвортой явууллаа. Түүнчлэн, гаалийн зуучлалын үйлчилгээний чанар, хэрэглэгчдийн тав тухыг нэмэгдүүлэх зорилгоор Гаалийн зуучлалын холбооны удирдах зөвлөлд компанийн удирдлагын багаас төлөөлөл орон ажиллаж эхлээд байна.

2025 оны үр дүн

- Гадаад: БНХАУ-ын Тяньжин хотод салбар компани байгуулаад 1 жил өнгөрч байна. Энэ хугацаанд тээврийн салбарт байршуулах өрсөлдөх чадвар, ялгарлыг хөгжүүлэн ажиллалаа. ОХУ-н салбар 2025 онд өндөр амжилттай ажиллаж өмнөх оноос ашгаа давуулан ажиллалаа.
- Дотоод тээвэр: Төмөр замын ачаалалай холбоотой авто замын тээвэр нэмэгдсэнээр Замын үүд -УБ хоорондын тээвэр нэмэгдсэнээр нийт тээврийн хэмжээ 41.2 мян.тн буюу өнгөрсөн жилээс 24%-иар нэмэгдсэн байна.

2026 оны хүлээлт

Зах зээлийн нөхцөл байдал болон хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагатай уялдуулан бид дотоод үйлчилгээ болон дагалдах үйлчилгээгээ хөгжүүлж ирсэн. 2026 онд бид тээврийн санхүүжилтын үйлчилгээнийхээ цар хүрээг нэмэгдүүлэх, хөгжүүлэхээр ажиллаж байна. Мөн, сүүлийн жилүүдэд хөгжүүлж буй агуулах, хүргэлтийн үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. Түүнчлэн, дэлхий нийтийн дижитал шилжилтийн чиг хандлагатай хөл нийлүүлж, бүтээмж болон харилцагчийн үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх зорилгоор дотоод цахим систем, хэрэглэгчийн цахим системүүдийг эрчимтэй хөгжүүлэхээр ажиллаж байна.

2026 ОНЫ ЗОРИЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2026 оны санхүүгийн төлөвлөгөө

Хүлээлт 2026 (тэрбум.төгрөг)	2025	2026 төлөвлөгөө
Цэвэр ашиг	9.3	13-14
Цэвэр ашгийн хувь	3.3%	4.0%

2026 оны санхүүгийн төлөвлөгөөний суурь таамаглал

Монложистикс групп нь 2026 оны бизнес төлөвлөгөөндөө эдийн засгийн өсөлтийг 6%, ам.долларын жилийн дундаж ханшийг 3,681 төгрөг (4.5%-ийн өсөлт), Монгол Улсын

ложистикийн салбарын өсөлтийг 19% байхаар тус тус төлөвлөсөн. 2026 онд групп нь дотооддоо бүтээмжийг нэмэгдүүлж, зардлын өсөлтийг хязгаарлахын зэрэгцээ гадаад талдаа үйлчилгээний чанар, нэр төрлийг нэмэгдүүлэн, харилцагчдад үнэ цэн бий болгосон хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар өсөлтийг хангахаар төлөвлөж байна. Зах зээлийн гадаад болон дотоод хүчин зүйлс өндөр хэлбэлзэлтэй, тодорхойгүй хэвээр байгаа энэ үед урт хугацааны хөгжлийг дэмжих зорилгоор дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийж, өрсөлдөх давуу талыг бий болгохоор төлөвлөж байна.

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын дүн (сая.төгрөг)	Төлөвлөгөө	Зарцуулалт	Үлдэгдэл
1. Хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт	8,062	4,562	3,500
2. Эргэлтийн хөрөнгө	2,923	2,923	0
3. Төв Азийн Зам ХХК		3,500	-3,500
Нийт	10,985	10,985	0

1. Хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт

Монложистикс Групп нь бизнесийн үр ашгаа нэмэгдүүлэх, өрсөлдөөний давуу талуудыг бий болгох зорилгоор дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт хийхээр 2 цуваа буюу 100 ширхэг 13-6953 загварын тавцант вагоныг ОХУ-аас худалдан авахаар төлөвлөсөн. Гэвч дотоод болон гадаад хүчин зүйлс,тухайлбал Төмөр замын тээврийн тухай хуулийн хэрэгжилт, дотоодын вагоны эрэлт хэрэгцээ мөн хөрш орны дайны нөхцөл байдал зэргээс шалтгаалан вагоны тоо ширхэг, хөрөнгө оруулалтын хугацаа болон вагоны төрөлд өөрчлөлт оруулахаар Монложистикс Холдинг ХК-ийн ТУЗ-өөс шийдвэрлэсэн. Үүний дагуу ОХУ-аас 50 ширхэг 12-1293 загварын ачааны хагас вагон шинээр худалдан авч, 2025 оны II хагасаас эхлэн тээврийн үйл ажиллагаанд оролцож эхэллээ. Бид 50 ширхэг вагоны гэрээний төлбөрт 8 тэрбум төгрөг төлсөн бөгөөд үүний 4,5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн хөрөнгөөс зарцууллаа.

2. Эргэлтийн хөрөнгийн санхүүжүүлэлт

Охин компаниудын үйл ажиллагааг өргөжүүлэх, өсөлтийг дэмжих, стратеги төлөвлөгөөг хангахын тулд эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор 2,9 тэрбум төгрөгийг зарцуулсан.

3. Шинэ бизнес: М&А - Төв Азийн Зам ХХК

Монложистикс Групп нь тээвэр ложистикийн салбарт үйл ажиллагаа нь жигдэрсэн, зах зээл дээр хэдийн байршсан компани худалдан авах замаар бизнесийн цар хүрээ, зах зээлд эзлэх байр сууриа тэлэхээр ТЭСО Группийн охин компани болох Төв Азийн Зам ХХК-ийг худалдан авах, хөрөнгө оруулах замаар хяналтын багц буюу 51%-ийг өөртөө нэгтгэсэн. Энэхүү хөрөнгө оруулалтад 3,5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн хөрөнгөөс зарцууллаа.

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Бид нийгэм, байгаль орчин, засаглалын хүрээнд олон ажлуудыг төлөвлөж, ISO 9001:2015 стандартыг амжилттай хэрэгжүүлж байгаа нь тогтвортой хөгжлийн 17 зорилгод өөрсдийн хувь нэмрийг оруулж байгаагийн том илрэл юм.

37%

ДӨРӨВ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ЖИЛ
АЖИЛЛАЖ БАЙГАА АЖИЛТНУУД

36%

GENERATION Z

49%

GENERATION Y



НИЙГЭМ БА БАЙГАЛЬ ОРЧИН

Монложистикс группийн урт хугацаанд тогтвортой, өрсөлдөх чадвартай хөгжиж, алсын хараа болон эрхэм зорилгодоо хүрэх үндэс суурийг бий болгоход чиглэсэн Тогтвортой хөгжлийн бодлогын баримт бичгийг Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталлаа. Компанийн бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлж болох гадаад, дотоод орчны эрсдэл, боломжуудыг тогтмол үнэлж, үр нөлөөтэй удирдан зохицуулах замаар оролцогч талуудад үнэ цэн бүтээх тогтолцоог хөгжүүлэх удирдлагын амлалтын мөн Тогтвортой хөгжлийн бодлогод тусгаж өгсөн.

“Logistics: Дэлхий рүү тэмүүлсэн он жилүүд”

Тээвэр ложистикийн салбарын түүхэн үүсэл, хөгжлийн үе шат, эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө, зах зээлийн шилжилтийн үед оруулсан хувь нэмэр, одоо тулгарч буй сорилт, хэтийн ирээдүйг нэгдсэн байдлаар тусгаж, анхаарч авч үзсэн эх сурвалж, баримт бичиг хомс байдгийг харгалзан, манай хамт олон 20 жилийн ойгоо тохиолдуулан салбарынхаа түүхийг нэгтгэж, зөвхөн Монгол Улсынхаа төдийгүй дэлхийн тээвэр ложистикийн хөгжил, туулж ирсэн зам, хуримтлуулсан туршлага, цаашдын чиг хандлагын таамаглал гэх зэргээр ложистикийн салбарын нэгдмэл дүр төрхийг дэлгэн харуулах номыг эрхлэн гаргахыг зорьсоны үр дүнд “Logistics: Дэлхий рүү тэмүүлсэн он жилүүд” ном удахгүй хэвлэгдэн гарах гэж байна. Тээвэр ложистикийн салбарын мэргэжилтнүүд, энэ

мэргэжлээр суралцагч оюутан залуучууд, салбарын талаар мэдлэг, мэдээлэл авахыг хүсэх бүх хүмүүст хүртээмжтэй нэгэн бүтээл болж чадна гэдэгт итгэлтэй байна.



Сагсан бөмбөгийн спортыг дэмжигч

Монложистикс Групп Монголын сагсан бөмбөгийн шилдэг багуудын нэг болох Сэлэнгэ Бодонс, хөгжлийн лигийн Умардын буганууд багуудтай хамтын ажиллагааны гэрээ байгууллаа. Энэхүү хамтын ажиллагаа нь баг тамирчдын амжилтад дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ, Монголын сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж буй чухал үйл явдал юм. Мөн 2025 оны 5-р сарын 30-31-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан Азийн аваргуудын лигийн зүүн бүсийн финалын тоглолтын хамтрагчаар ажиллалаа.





ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭР

Монложистикс Групп нь уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн бага нөлөөлөлтэй төмөр замын тээврээр уул уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд анхаарч ажиллаж байна. Монложистикс Группийн хэмжээнд 2025 онд нийт 809 мянган тонн ачаа тээвэрлэснээс дийлэнх хувийг буюу ?? мянган тонн ачааг төмөр замаар тээвэрлэсэн байна. Монложистикс Групп байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл хамгийн багатай тээврийн төрөл болох төмөр замын тээвэрт илүү анхаарч өөрийн эзэмшлийн 50 ширхэг ачааны хагас вагон худалдан авсан нь уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах, эрүүл мэндийг дэмжих, инновац болон дэд бүтцийг хөгжүүлэх зэрэг тогтвортой хөгжлийн олон зорилгуудад нийцсэн үйл ажиллагаа явуулж байгааг илтгэж байна. Монложистикс Групп нь Монголын эрдэс баялгийн салбарын хамгийн том арга хэмжээ болох MinePro Mongolia 2025-д тээвэр ложистикийн цогц шийдэл, төслийн ачаа, дараа төлбөрт уян хатан тээврийн нөхцөлүүдээ танилцуулж оролцсон нь эрдэс баялгийн салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж, хариуцлагатай уул уурхайг өргөжүүлэн хөгжүүлэхэд тээвэр ложистикийн гүйцэтгэх үүрэг өндөр болсонтой холбоотой.



ШАМБАЛА 2056

Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтуудын хүрээнд хуурай газрын экосистемийг урт хугацаанд хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр нөлөөг урлаг, технологи ашиглан бууруулах зорилготой "Шамбала-2056" төсөлтэй бид хамтран ажилладаг. Дорноговь аймгийн Эрдэнэ сум, Төхөмийн хөндий, Ар цэцэн ус буюу нэн цөлжилттэй газар нутагт 2016 оноос 2056 он хүртэл 40 жилийн хугацаанд хэрэгжих уг төслийн үр дүнд хайлаас мод бүхий ногоон зурвас үүсээд байна.

2024 оноос эхлэн "Шамбала-2056" төслийн талбай дахь модны хяналтыг NASA MODIS хиймэл дагуулын системээр дамжуулан хийж, тооцоолол болон хөндлөнгийн аудитын зарим үйл ажиллагааг MARTENSITE ANALYTICA компани гүйцэтгэж байна.

Монложистикс Групп нь энэхүү төслийг дэмжин хамтран ажилласнаар дараах үр нөлөөг байгаль, экологид бодитоор үзүүлж, холбогдох батламжийг гардан авсан. Үүнд:

➤ Нүүрстөрөгчийн хуримтлал
t[C] - 186.688 t[C] +/-29.496

➤ Биомассын ялгарал
(t) - 397.209 t[C] +/-62.759



Do good hub 2025



"Do Good Hub" төв нь 2023 оны 09-р сараас хойш үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж, Монложистикс Групп 4 дэх жилдээ санхүүжүүлж, дэмжин ажиллаж байна.


"Do Good Hub" дээр үйл ажиллагаагаа явуулдаг төрийн бус байгууллагуудаар дамжуулан залуучуудын оролцоог дэмжих, дуу хоолойг нийгэмд хүргэх, залуучуудын сайн дурын үйл ажиллагааг идэвхжүүлэхэд чиглэсэн олон ажлууд хийгдсээр байгаа юм.



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

Монложистикс Групп нь 2025 оны төгсгөлд 8 компанийн нийт 217 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Нийт ажилтнуудын тоо: **217**



Эрэгтэй 38%

Эмэгтэй 62%

Группийн хүний нөөцийн бодлого нь тогтвортой хөгжлийн стратегид нийцүүлж, компанийн болон салбарын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, боломж, эрсдэлийг тооцож, компанийн үнэт зүйлсийг бүтээх мэргэшсэн хамт олныг бүрдүүлэх цогц, урт хугацааны стратеги бөгөөд группийн нийт ажилтнуудынхаа эрүүл мэнд, сургалт хөгжил, багийн ажиллагаа, бүтээмжийн өсөлтийг дэмжсэн олон арга хэмжээнүүдийг 2025 онд зохион байгууллаа.

Бид өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлж ирсэн, ажилтны бүтээмж болон сайн сайхан байдлыг нэмэгдүүлэх төдийгүй манай группийн хөдөлмөрийн зах зээл дэх нэр хүндийг өсгөж, илүү таниулж өгсөн, “Ажиллахад таатай орчин” шагнал, “Entrepreneur-2023” болон “Entrepreneur-2025” шагналуудыг хүртэх, “Сургалт хөгжлийг дэмжигч шилдэг ажил олгогч”, “Шилдэг соёл бүхий ажил олгогч” шагналуудад өрсөлдөх нөхцөлүүд болж ирсэн өрсөлдөхүйц цалин хөлс, өргөн хүрээтэй хөнгөлөлт хангамж, зээлийн нөхцөл, уян хатан цагийн зохицуулалт, зайнаас ажиллах боломж зэрэг ажилтанд ээлтэй бодлогуудаа улам сайжруулсаар, цаг үеийн нөхцөл байдалд нийцүүлэн хүний нөөцийн уян хатан бодлого хэрэгжүүлсээр байна.

Ажилтнуудад зориулсан ESOP хуримтлалын хөтөлбөр, ажилласан жилийн нэмэгдэл цалингийн систем, сургалт хөгжлийн хөтөлбөрүүд нь группийн хэмжээнд 4 ба түүнээс дээш жил тогтвортой ажиллах ажилтнуудын тоог улам нэмэгдүүлж байгааг тоон мэдээлэл батлан харуулж байна.

Бид замын хөдөлгөөний ачаалал ихтэй бүсээс ирдэг ажилтнууддаа өглөө эрт эсвэл оргил ачааллын дараа ирэх боломжийг олгож ажлын уян хатан цагийн зохицуулалтдаа өөрчлөлт оруулах, зайнаас ажиллах эхжүүд болон онцгой нөхцөл байдлаас шалтгаалан зайнаас ажиллах нөхцөлийг нэмэгдүүлэх зэрэг уян хатан шийдлүүдийг байнга эрэлхийлж байдаг билээ. Бид 2025 онд хийж хэрэгжүүлсэн ажлуудаа группийн 5 үнэт зүйлстэй уялдуулан тайлагнаж байна.

1. Өндөр чадвартай мэргэжлийн хамт олон

Монложистикс Группийн ажилтан бүр өөрийгөө олж нээн, авьяас чадвараа суралцах хүсэл эрмэлзэлтэйгээр өсч хөгжихөд нь компани туслах замаар өндөр чадвартай мэргэжлийн хамт олныг бүрдүүлэх хүний нөөцийн стратегийн хүрээнд 2025 онд сургалт хөгжлийн бодлого, төлөвлөгөөний дагуу олон ажлуудыг зохион байгуулж ажиллалаа.

Employee day 2025

Ажил олгогчийн брэндингийг дотооддоо таниулах замаар нийт ажилтнуудын сэтгэл ханамжтай, бүтээмж өндөр, тогтвортой ажиллахад нөлөөлж, нээлттэй хувьцаат компанийн ил тод байдалд тулгуурлан, зах зээлийн тэргүүлэгч байгууллагын бизнесийн алсын харааг амжилттай хэрэгжүүлэхийн тулд ажилтан бүрийн оролцоог нэмэх зорилгоор Монложистикс Групп нь 5 дахь жилдээ “EMPLOYEE DAY” арга хэмжээг 2025 оны 6-р сард “Бүтээлч хамт олон” уриан дор 7 өдрийн турш амжилттай зохион байгуулагдлаа.

Группийн хэмжээнд зохион байгуулсан “Employee Day-2025” арга хэмжээний нээлтийн өдөр бид группийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс, 2030 он хүртэлх стратегийн хүрээ, 2025–2026 оны гол зорилтууд, хэрэгжиж буй төслүүд болон тэдгээрийн үр дүнг хамт олонтойгоо хуваалцан, тэдний санал бодлыг сонсож, харилцан ойлголцол, итгэлцлийг гүнзгийрүүлсэн ач холбогдолтой арга хэмжээг зохион байгууллаа. Нээлтийн арга хэмжээнд Ондо ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Мандуул өөрийн карьерын замнал, амжилт ба сорилт, ирээдүйн зорилго төлөвлөгөөний тухай чөлөөт ярилцлага өрнүүлж, Дэйл Карнеги Трейнинг Монгол төвийн сургагч багш А.Даваасүрэн багийн ажиллагаа, бүтээмжийн чиглэлийн сургалтаар ажилтнуудад мэдлэг, туршлагаа хуваалцсан юм.



Арга хэмжээний дараагийн өдрүүдэд ажилтан бүрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, шинэ мэдлэг туршлага хуримтлуулахад чиглэсэн сургалт, хэлэлцүүлгүүд, урам зориг өгөх зочдын оролцоотойгоор өрнөлөө. Санхүүгийн зөвлөх, хөрөнгө оруулалтын аналитс, зохиолч А.Идэрбат санхүүгийн боловсрол, хөрөнгө оруулалтын сэдвээр сургалт явуулж, ажилтнууд группийн хэмжээнд хэрэгжиж буй ESOP хөтөлбөрт хамрагдаж, урт хугацааны хуримтлалтай болохын давуу талыг бататгаж өгсөн. Сэтгэл Судлалын Үндэсний Төв ТББ-ын Гүйцэтгэх захирал, сэтгэл судлаач Б.Ууганцэцэг “Сэтгэл зүйн эрүүл байдал, амьдралын чанар” сэдвээр; Мэргэшсэн хоол зүйч С.Мөнхцэцэг “Эрүүл зөв хооллолт”-ын талаар мэдлэг олгож, ажилтнуудтай илэн далангүй ярилцлаа. Ажилтнууд MLC Business School-ийн “TALENT BOX” хөтөлбөрт хамрагдаж, хувийн бүтээмжээ нэмэгдүүлэх практик арга барилд суралцсан нь арга хэмжээний үр өгөөжийг улам нэмэгдүүлсэн юм.



МВА хөтөлбөр

Ажилтан бүр мэдлэг оюунаа тэлж, мэргэжлийн болон ерөнхий ур чадвараар цаг үетэйгээ хөл нийлүүлэх, тасралтгүй суралцах байдлыг дэмждэг бусдыг хүчирхэгжүүлэх манлайллын соёл үнэт зүйлийн хүрээнд 2023 оноос эхэлсэн МВА хөтөлбөр амжилттай үргэлжилж байна. Компанийн тэтгэлэгт хөтөлбөрт 8 ажилтан хамрагдсаны 5 нь СЭЗИС-ийн Бизнесийн ахисан түвшний сургуулийн Магистрийн хөтөлбөрийг 2025 онд амжилттай дүүргэж, магистрын зэрэг хүртлээ.



Дотоод ментор хөтөлбөр

Группийн удирдах албан тушаалтнуудыг улам чадавхжуулах зорилготой дотоод ментор хөтөлбөр амжилттай хэрэгжлээ. Монложистикс Холдинг ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болох Мандал санхүүгийн нэгдлийн ТУЗ-ийн дарга Ө.Ганзориг, Олон улсын санхүүгийн корпорацийн Компанийн засаглалын хөтөлбөрийн зөвлөх Э.Оюунбилэг нар уг хөтөлбөрийн ментораар ажиллаж, 6 залуу захирал, менежерүүдийг бүтэн жилийн турш менторлосон юм.

Ажилтнуудын зөөлөн ур чадваруудыг хөгжүүлэх, менторын мэргэшсэн мэргэжлийн ур чадвараас суралцах боломжийг олгох, байгууллагын дотоод залгамж халааг бэлтгэх чухал ач холбогдолтой энэхүү хөтөлбөр 2026 онд үргэлжлэн хэрэгжиж байна.



2. Инновацлаг багийн сэтгэлгээ

Бүтээмжийг нэмэгдүүлэх бүрэн дижитал орчин

Бүрэн дижитал орчин бүрдүүлэх стратегийн хүрээнд бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр олон ажлыг шат дараатай хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд ажилтнуудын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдах, цаг хэмнэх дижитал шийдлүүдийг тасралтгүй боловсронгуй болгож байна.

2025 онд Microsoft 365 платформ руу шилжиж, Odoo ERP системийн модулиудыг компанийн хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлснээр үйл ажиллагааны үр ашиг нэмэгдэж, цаг хэмнэлт бий болсон төдийгүй олон талын давуу нөхцөл бүрдсэн.

ERP системийн хүрээнд цахим сургалтын E-Learning модуль, баримт бичгийн цахим бүртгэлийн Document Management System, харилцагчийн удирдлагын CRM модуль зэргийг нэвтрүүлсэн. Үүнээс гадна ажилтнууд компанийн дотоод дүрэм, журам болон шаардлагатай мэдээллийг AI chatbot ашиглан шууд асууж, хариулт авах боломж бүрдсэнээр мэдээлэлд хандах хурд, хүртээмж эрс сайжирсан.

Мөн 2025 онд E-Learning модульд сургалтын агуулга, контентыг цахим хэлбэрээр системтэйгээр хөгжүүлж, өндөр чанартай сургалтуудыг тогтмол бэлтгэн ажилтнуудын мэдлэг, ур чадварыг тасралтгүй дээшлүүлж байна.



3. Бусдыг хүчирхэгжүүлэх манлайллын соёл

Future CEO хөтөлбөр

Монложистикс Групп нь бусдыг хүчирхэгжүүлэх манлайллын соёл үнэт зүйлсийн хүрээнд оюутан залуусын ирээдүйн хөгжилд оюунлаг хөрөнгө оруулалт хийх "Future CEO" тэтгэлэгт хөтөлбөрийг 2 удаа хэрэгжүүлсэн бөгөөд одоо уг хөтөлбөрт шалгарсан оюутнуудын зарим нь сургуулиа амжилттай төгсөн, групптээ ажиллаж байна.

Урлагын наадам зохион байгууллаа

Ажилтнуудын авьяасыг нээн хөгжүүлэх, оролцоо, бүтээлч байдал, багийн ажиллагааг дэмжих зорилготой Монложистикс Группийн "Урлагийн Их Наадам" амжилттай зохион байгуулагдаж, группийн 200 гаруй ажилтнууд нийт 6 багт хуваагдан авьяас чадвар, бүтээлч багийн ажиллагаа, эрч хүчээрээ өрсөлдсөн юм. Гурван жилд нэг удаа зохион байгуулагддаг "Урлагийн Их Наадам" нь энэ удаад Монложистикс Групп үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ойн арга хэмжээг угтан зохион байгуулсан онцлог нэгэн арга хэмжээ боллоо.



MLG Hiking Club-ийн алхалтууд амжилттай үргэлжилж байна

Монложистикс Группийн сонирхол, хоббигоороо нэгдсэн залуусын санал санаачлагаар байгуулагдсан “MLG Hiking Club” нь нийт ажилтнуудын бие болон сэтгэлзүйн эрүүл мэндийн төлөө хамт олноо уриалан, өнгөрсөн 2 жилийн хугацаанд давхардсан тоогоор 258 ажилтныг хамруулсан нийт 42 удаагийн, 2643 км замыг 1078 цагт туулсан алхалт, авиралтуудыг амжилттай, аюулгүй зохион байгуулаад байна. Алтай Таван Богд уулын Хүйтэн оргил /ДтД 4374м/, Малчин оргил /ДтД 4050м/-уудад Монложистикс Холдинг ХК-ийн Гүйцэтгэх удирдлагын баг 2023 оны 8-р сард анх оргилдсон бол 2025 оны 8 дугаар сард Монгол Улсын Гавъяат уулчин Б. Гангаамаатай хамт клубын 5 гишүүн амжилттай оргилдсон. 2026 онд мөн 5 гишүүн Хүйтэн оргилд авиралт хийх эрхээр шагнуулаад байна.



4. Шударга, ил тод байдал

Манай бүх үйл ажиллагаа том жижиг, их багаас үл хамааран үнэнч шударга байх зарчим дээр суурилан бүхий л оролцогч талуудад шаардлагатай мэдээллийг нээлттэй, ойлгомжтой, үнэн зөвөөр цаг ямагт хүргэж байх үнэт зүйлийнхээ дагуу ажиллаж байна. Энэ хүрээнд Монложистикс Группийн хэрэглэгч, үйлчлүүлэгч нар ачаатай холбоотой бүхий л мэдээллийг Logistics Management System-ээр дамжуулан шуурхай авах нөхцөл, боломжийг улам бүр боловсронгуй болгосоор байна.

Монложистикс группийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх хууль ёсны бөгөөд ёс зүйн хэм хэмжээг тогтоон хэвшүүлснээр ёс зүйтэй, эрүүл сайн засаглалыг бэхжүүлж, тогтвортой хөгжих, өрсөлдөх чадварыг баталгаажуулах, компанийн үйл ажиллагааг хэвийн, тогтвортой явуулах зорилго биелэгдэх юм. Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ёс зүйн дүрмийг шинэчлэн батлаж, нийт ажилтнууд бизнесийн ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэн дээдэлж, дагаж мөрдөх, зөрчигдсөн гэж үзсэн тохиолдолд шүгэл үлээх системээр дамжуулан шүгэл үлээх тухай сургалтын зохион байгуулсан.

ESOP хуримтлалын хөтөлбөр

Ажилтан болон ажил олгогчийн хамтран бий болгох тогтмол хуримтлалыг тэдний шууд оролцоо, хяналтын дор мэргэжлийн хөрөнгө оруулалтын компани удирдан өсгөж, үр өгөөж бий болгосноор ажилтны ирээдүйн санхүүгийн баталгааг сайжруулах хуримтлалын хөтөлбөр хэрэгжээд 3 жил болж байна.

Хөтөлбөрийн зорилго:

- Ажилтнаа урамшуулах, тэдгээрийн санхүүгийн чадварыг нэмэгдүүлэх, ирээдүйн санхүүгийн баталгааг хангах
- Ажилтан болон ажил олгогчийн хамтын зорилгыг бий болгох
- Үр ашигтай, олон улсын жишигт нийцсэн, хуулийн хүрээн дэх ажилтны хамтарсан хуримтлалын санг бий болгох
- Тогтвортой хүний нөөцийг цогцлоох



5. Хариуцлага, сахилга бат

ХАБЭА-н бодлого, холбогдох журмуудыг олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэн баталсан бөгөөд 2025 онд зохион байгуулсан ХАБЭА-н сургалтад нийт сургалтын цагийг давхардалгүй хамрагдсан ажилтны тоонд харьцуулан тооцоход нэг ажилтанд ногдох сургалтын жилийн дундаж хугацаа 4.10 цаг байна. Үүнээс нийт 115 орчим ажилтан 4 цагийн ХАБЭА-н ерөнхий сургалтад хамрагдсан бөгөөд удирдлагын түвшний ХАБЭА-н сургалтад нийт 6 ажилтан хамрагдсан.



Бүх ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамрууллаа

Нийт ажилтнуудынхаа эрүүл мэндийг дэмжих, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилготой зохион байгуулсан эрүүл мэндийн үзлэгт Монложистикс Группийн нийт ажилтнууд 2025 оны 3-р сарын 15-наас 5-р сарын 15-ны хооронд Интермэд эмнэлэгт багц шинжилгээнүүд, дурангийн болон бусад нарийн мэргэжлийн үзлэгүүд хийлгэж, эрүүл мэндийн иж бүрэн үйлчилгээнд хамрагдлаа. Эрүүл мэндийн үзлэг нь ажилтнуудын амьдралын чанар, ажлын бүтээмжийг дэмжих, аливаа өвчнийг эрт үед нь илрүүлэх, эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах зорилготой, компанийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн бодлогын нэг хэсэг юм.

ЗАСАГЛАЛ

Компанийн сайн засаглалыг бэхжүүлэх, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж, компанийн гүйцэтгэх удирдлагыг удирдан чиглүүлэх, хянах тогтолцоог хэрэгжүүлэхэд Төлөөлөн Удирдах Зөвлөл манлайлан ажиллалаа.

89%

төлөвлөгөөний гүйцэтгэл

III БАЙР


КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ҮНЭЛГЭЭ



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

Хувьцаа	2023.12	1344
ЭЗЭМШИГЧДИЙН	2024.12	1481
ТОО:	2025.12	3803

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц:



ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

I. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

Монложистикс Холдинг ХК-ийн эрх барих дээд байгууллага болох хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр 87.74%-ийн ирцтэйгээр амжилттай зохион байгуулагдсан. Хурлыг хувьцаа эзэмшигчдийн хурлын платформыг ашиглан зайнаас буюу цахим хэлбэрээр хуралдуулж, шууд дамжуулалтыг хурлын платформоор болон фэйсбүүк дэхь Monlogistics Group пэйж хуудсаар олон нийтэд хүргэсэн. Хувьцаа эзэмшигчдийн хуралд:

- Гүйцэтгэх захирал бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Г. Хишигбат компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлахын өмнө компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг товч танилцуулж;
- ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудит, Эрсдэлийн удирдлагын хорооны дарга Э. Оюунбилэг компанийн ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж;
- Хөндлөнгийн аудитор Грант Торнтон ХХК-ийн аудитын багийн гэрээт ажлын партнер Н. Эрдэнэцог компанийн санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг тус тус танилцуулж, хувьцаа эзэмшигчдээс ирсэн асуултанд хариулж оролцсон.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар:

- Монложистикс Холдинг ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батласан.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



Лувсанжамба **ГАНЗОРИГТ**

Үүсгэн байгуулагч ба
ТУЗ-ийн дарга

Санхүү, олон улсын худалдааны
чиглэлээр 31 жилийн туршлагатай.



Бааст **ТЭЛЭНГЭД**

Үүсгэн байгуулагч, ТУЗ
ийн ердийн гишүүн

Тээвэр ложистикийн салбарт 31
жилийн туршлагатай.



Ганзоригт **ХИШИГБАТ**

ТУЗ-ийн ердийн гишүүн

Санхүү, хөрөнгө оруулалтаар
11 жил, засаглал удирдлагын
чиглэлээр 8 жилийн
туршлагатай.



Өлзийбаяр **ГАНЗОРИГ**

ТУЗ-ийн ердийн гишүүн

Банк, санхүү, даатгалын салбарт
23 жилийн засаглал, гүйцэтгэх
удирдлагын туршлагатай.



Эрэндоо **ОЮУНБИЛЭГ**

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Банк санхүүгийн салбарт 31
жилийн компанийн засаглалын
мэргэшсэн туршлагатай.



Балдан **ЭНХТҮВШИН**

ТУЗ-ийн ердийн гишүүн

Банк, санхүү, даатгалын салбарт
21 жилийн засаглал, гүйцэтгэх
удирдлагын туршлагатай.



Санжаа **САЙНБАТ**

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Худалдаа үйлчилгээний салбарт
засаглал удирдлагын чиглэлээр
21 жилийн туршлагатай.



Готов **ЦЭРЭНПҮРЭВ**

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Олон улсын банк санхүүгийн
салбарт 41 жилийн удирдах
чиглэлийн туршлагатай.



Сэнгээ **ЭНХ-АМГАЛАН**

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Бизнесийн удирдлага, засаглал,
гүйцэтгэх удирдлагын 23 жилийн
туршлагатай.



Цогт **ДУЛАМСҮРЭН**

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Хүний нөөц, захиргаа, эрх
зүй, засаглалын 21 жилийн
туршлагатай.

II. Төлөөлөн удирдах зөвлөл


Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл юм. Хурдацтай өөрчлөгдөж буй бизнесийн талбарт үүсч болох эрсдэл ба боломжийг амжилттай удирдах чадвартай, салбар салбартаа мэргэшсэн, туршлагатай гишүүдээс Монложистикс Холдинг ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл бүрддэг бөгөөд ердийн 5, хараат бус 4, нийт 9 гишүүнтэй.

III. ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тайлан


ТУЗ-ийн хурал

Монложистикс Холдинг ХК-ийн ТУЗ нь 2025 онд ээлжит болон ээлжит бус нийт 7 удаагийн хурал зохион байгуулж, гишүүд идэвх санаачлагатай оролцсон бөгөөд хурлын дундаж ирц 88%. Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд ТУЗ-ийн хурал болон ТУЗ-ийн гишүүдээс эчнээ санал хураалт явуулах замаар 2025 онд ТУЗ-өөс нийт 50 тогтоол шийдвэрийг баталсан.

ТУЗ-ийн хурал / Ирцийн мэдээлэл




ТУЗ-ийн хурал / тогтоол 50



ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурал

ТУЗ-ийн дэргэдэх хороод нь 2025 онд биечлэн болон цахим хэлбэрээр нийт 18 удаа хуралдаж, хороодын ажлын чиг үүргийн дагуу идэвх санаачлагатай ажилласан. Аудит, эрсдэлийн удирдлагын хороо нь компанийн эрсдэл, комплайнс, санхүү, нягтлан бодох бүртгэлийн удирдлагад хөндлөнгийн аудитууд болон Дотоод аудитор, нийцэл хариуцсан ажилтнаар дамжуулан хяналт тавих, удирдан чиглүүлэх өргөн чиг үүрэгтэй ажилладаг бөгөөд 2025 онд нийт 8 удаагийн хурал, 2 удаагийн ажлын уулзалтаар нийт 11 зөвлөмж, дүгнэлт гарган ажилласан байна.

ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурал / хэлэлцсэн асуудал



ТУЗ-ийн цалин, урамшуулал

2024 оны 4-р сард хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн батлуулсан ТУЗ-ийн гишүүдийн цалинд 2025 онд өөрчлөлт ороогүй бөгөөд компанийн жилийн төсвийн хүрээнд ТУЗ-ийн гишүүдэд үндсэн цалин болон хорооны даргын нэмэгдэл, хорооны гишүүний нэмэгдлийг тус тус тогтмол дүнгээр тооцож, дараах нийт цалинг ТУЗ-ийн гишүүдэд олгосон.

№	Зардлын задаргаа	Нийт зардал
1	ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардал	182,400,000 ₮
2	Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	22,800,000 ₮
НИЙТ ЗАРДЛЫН ТӨСӨВ		205,200,000 ₮

Гүйцэтгэх удирдлагын цалин урамшуулал нь ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан үндсэн цалин болон жилийн эцсийн ашигт ажиллагаа, стратегийн гүйцэтгэлээс хамаарсан урамшуулалт цалингаас бүрдэнэ. Тайлант онд гүйцэтгэх захирлын үндсэн цалинг нэмэгдүүлээгүй бөгөөд урамшуулал олгох шалгуур үзүүлэлт өөрчлөгдөөгүй.

ТУЗ-ийн хөгжил, сургалт

ТУЗ-өөс 2025 онд сургалт хөгжлийн бодлогын хүрээнд дараах сургалт, арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Монголч эрдэмтэн, антропологич, Чингис хааны одонт, түүхч эрхэм Жак Уэтерфорд гуайтай 2025 оны 11 дүгээр сарын 20 буюу Эзэн Чингис хаана мэндэлсэн Монгол бахархлын өдөр хийсэн уулзалт, арга хэмжээнд ТУЗ-ийн гишүүд, группийн удирдах албан тушаалтнууд оролцлоо.



Удирдлагын хөгжлийн шинэ чиг хандлага сургалтыг Компанийн Засаглалын Хөгжлийн Төвтэй хамтран зохион байгуулсан бөгөөд сургалтад ТУЗ-ийн гишүүд болон группийн захирлуудыг хамрагдсан.

Стэнфордын их сургуулийн “Дижитал шилжилт” сэдэвт 6 модуль сургалтыг хялбаршуулан ТУЗ-ийн гишүүдийг хамруулсан.



ТУЗ-ийн үнэлгээ

“Монложистикс Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн гүйцэтгэлийг үнэлгэх журмын хэрэгжилтийг хангаж ажилласан. Эрнст энд Янг аудитын компанийн боловсруулсан “Үр нөлөөтэй ТУЗ-ийн засаглал” загвараар ТУЗ өөрийн үнэлгээг хийсэн нь засаглалын чанарыг системтэй



сайжруулах, ТУЗ-ийн бүтэц, үйл ажиллагаа, шийдвэр гаргалт, дотоод харилцаа, манлайлал гээд бүх түвшинг үнэлж, ТУЗ-ийн гаргасан шийдвэрүүд нь бодит үр дүнд хүрч байгаа эсэх, компанийн гүйцэтгэлд нөлөөлж байгаа эсэхийг бодитоор харуулах давуу талтай гэж үзсэн.

Эдгээр бүрдэл тус бүрийн үнэлгээний шалгуур асуултуудын дагуу ТУЗ-ийн гишүүд өөрийн үнэлгээ хийсэн бөгөөд Монложистикс Холдинг ХК-ийн ТУЗ-ийн үр нөлөөтэй байдал нь 80% гэж үнэлэгдсэн. “ТУЗ-ийн шийдвэр гаргалт” үзүүлэлтээр хамгийн өндөр буюу 87% үнэлгээтэй гарсан бол “ТУЗ-ийн үйл ажиллагаа” үзүүлэлт хамгийн бага буюу 72%-ийн үнэлгээтэй гарсан. Үнэлгээний үр дүн болон шалгуур асуултад хангалтгүй үзүүлэлттэй байгаа хэсгийг сайжруулах ажлыг 2026 оны ТУЗ-ийн ажлын төлөвлөгөөнд тусгасан.

Нэр Дэвшүүлэх болон Цалин Урамшууллын Хороо нь ТУЗ-ийн болон Гүйцэтгэх удирдлагын 2025 оны ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэлтийг ТУЗ-ийн 2025 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хуралд танилцуулж, хэлэлцүүлсэн.

ТУЗ-ийн 2025 оны ажлын гүйцэтгэлийн нэгдсэн тайланг дараах хүснэгтэд харуулав.

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжүүр	Үнэлгээ	Тайлбар
1	КЗК-д заасан шалгууруудыг хангаж байгаа эсэх	90% ба түүнээс дээш буюу Засаглал хэвийн/эрсдэлгүй түвшинд байх	95.8%	СЗХ-ны КЗК-ийн үнэлгээний тайлан (2025 оны эхний хагас жил)
2	ТУЗ-ийн хурлын ирц нь хангалттай түвшинд байгаа эсэх	ТУЗ-ийн хурлын ирц 80% ба түүнээс дээш хувийн ирцтэй байх	80.0%	ТУЗ-ийн 2025 оны ажлын төлөвлөгөөнөөс зарим ажлууд хийгдээгүй.
3	ТУЗ-ийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл хангалттай түвшинд байгаа эсэх	ТУЗ-ийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл 80% ба түүнээс дээш	89.0%	ТУЗ-ийн 7 удаагийн хурлын дундаж ирцийн үзүүлэлт
4	ТУЗ-ийн дэргэдэх хороодын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл хангалттай түвшинд байгаа эсэх	ТУЗ-ийн дэргэдэх хороодын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл 80% ба түүнээс дээш хувийн гүйцэтгэлтэй эсэх	79%	ТУЗ-ийн дэргэдэх хороодын 2025 оны ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл

IV. Компанийн засаглалын зарчмуудын хэрэгжилт, өөрийн үнэлгээ, хянан баталгаажилт


Компанийн засаглалын зарчмуудыг зөв зохистой хэрэгжүүлэх нь засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг нэвтрүүлэх замаар хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, итгэлцлийг бий болгох, компанийг эрсдэлээс хамгаалж, тогтвортой үнэ цэнийг бүтээх чухал ач холбогдогдолтой.

Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын удирдамж болон үнэлгээний аргачлал”-ын дагуу Монложистикс Холдинг ХК-ийн ТУЗ-өөс Монложистикс Холдинг ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-

ийн хэрэгжилтийг 2025 онд давтан үнэлсэн. “Монложистикс Холдинг ХК нь Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй байгаа нийт компаниудиа “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн 95,8%-ийн үнэлгээтэйгээр, эзлүүлсэн байр буюу засаглалын зэрэглэлээр 2025 онд 3-р байрт, Компанийн засаглалын үнэлгээгээр тэргүүлэгч ТОП 20 компанийн нэгээр шалгарсан.

Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны ангилал 2025 оны 9-р сард шинэчлэгдэж, Монложистикс Групп (MSE:MLG) нь I ангилал руу дэвшсэн. Монголын хөрөнгийн бирж дээрх хувьцаануудын арилжааны идэвх, зах зээлийн үнэлгээ, компанийнх нь засаглал, мэдээллийн ил тод байдал зэрэг олон шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан үзэж 3 ангилдаг бөгөөд MSE:MLG хувьцаа Монголын хөрөнгийн зах зээлд I ангилалд арилжаалагдах 25 хувьцааны нэг болсон.

Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээ болон зах зээлийн үнэлгээний харилцан хамаарал (10.0-100.0 тэрбум төгрөг хүртэл)




Ил, тод байдал

Монложистикс Групп нь үйл ажиллагаандаа бизнесийн ёс зүйн хэм хэмжээг чандлан сахиж, хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, олон нийтэд компанийн үйл ажиллагааны талаарх болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь нээлттэй мэдээлж, ил тод байршуулан, үнэн зөв, бүрэн гүйцэт, түргэн шуурхай тогтмол мэдээлэх зарчмыг баримтлан ажилладаг билээ.

2025 онд <https://investor.mlholding.mn/> цахим хуудсанд болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсанд дараах мэдээллүүдийг байршуулж, олон нийтэд нээлттэй мэдээллэсэн байна.

Нийтэд мэдээллэсэн тоо



ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ



Г. Хишигбат
Гүйцэтгэх захирал

Санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр 11 жил, засаглал гүйцэтгэх удирдлагын чиглэлээр 8 жилийн туршлагатай.



А. Одгэрэл
Ложистикийн зөвлөх

Тээвэр ложистикийн салбарт 18 жил, засаглал, гүйцэтгэх удирдлагын чиглэлээр 8



З. Шинэ-Од
Санхүү эрхэлсэн захирал

Худалдаа, үйлдвэрлэл, тээврийн салбарт санхүү менежмент чиглэлээр 13 жилийн ажлын туршлагатай.



Б. Ууганхүү
Стратеги, бизнес хөгжил эрхэлсэн захирал

Дэд бүтэц, үйл ажиллагааны менежментийн чиглэлээр 8 жил, засаглалын чиглэлээр 11 жилийн туршлагатай.



Т. Батзаяа
Технологи эрхэлсэн захирал

Мэдээлэл технологийн салбарт 18 жилийн технологи, гүйцэтгэх удирдлагын туршлагатай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Мэдээллийн технологийн хэлтэс

Санхүүгийн хэлтэс

Захиргаа, хүний нөөц, маркетингийн хэлтэс

Стратеги, бизнес хөгжлийн хэлтэс

Толгой компанийн бизнесийн үйл ажиллагааг Гүйцэтгэх захирал удирдан чиглүүлдэг ба Санхүү, Мэдээлэл технологи, Стратеги бизнес хөгжил, Захиргаа хүний нөөц, маркетинг гэсэн 5 хэлтэс харьяалагддаг.

ОХИН КОМПАНИУДЫН УДИРДЛАГА



И. Цогбаяр

Гүйцэтгэх захирал
Монложистикс Ворлдвайд ХХК

Стратеги, санхүү төлөвлөлт,
гүйцэтгэх удирдлагын чиглэлээр
9 жилийн туршлагатай.



Б. Тэлэнгэд

Гүйцэтгэх захирал
Монложистикс Транзит ХХК

Тээвэр ложистикийн салбарт
31 жилийн туршлагатай.



Г. Хишигбат

Гүйцэтгэх захирал
Монложистикс Экүйментс ХХК

Төмөр зам, тээвэр
ложистикийн салбарт 31
жилийн туршлагатай.



Э. Цолмонгэрэл

Гүйцэтгэх захирал
Төв Азийн Зам ХХК

Стратеги, бизнес төлөвлөлт,
гүйцэтгэх удирдлагын
чиглэлээр 15 жилийн
туршлагатай.



Н.Эрдэнэбилэг

Гүйцэтгэх захирал
Каус Аустралис ХХК

Төмөр зам, тээвэр
ложистикийн салбарт 31
жилийн туршлагатай.



Лункина.В.Н

Гүйцэтгэх захирал
Монложистикс Транс
Сервис ХХК

Төмөр зам, тээвэр
ложистикийн салбарт 23
жилийн туршлагатай.



Гуо Хонглиан

Гүйцэтгэх захирал
Тяньжин РТ Ложистикс ХХК

БНХАУ-ын төмөр зам, далайн
тээврийн салбарт 30 жилийн
туршлагатай

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

MSE:

MLG

Гаргасан нийт хувьцаа:

395,858,822 ширхэг

2025 оны эцсийн хаалтын ханш:

190 төгрөг

Зах зээлийн үнэлгээ:

75.2 тэрбум төгрөг

Компанийн зах зээлийн үнэлгээ 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 75,2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Тайлант хугацаанд компанийн 7,811,167 ширхэг үнэт цаас нийт 1,457,035,330.17 төгрөг буюу өдөрт дунджаар 32,820.03 ширхэг хувьцаа 6,121,997.19 төгрөгөөр арилжаалагджээ.

- 2025-12-31 хаалтын ханш 189.99 төг
- 2025 оны дундаж ханш 185.40 төг
- Хамгийн ихдээ 204.97 төг (2025.04.29-ний өдөр),
- Хамгийн багадаа 170.11 төг (2025.09.17-ны өдөр) байв.



НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

“Монложистикс Холдинг” ХК-ийн үйл ажиллагаа болон стратегийн бодлоготой уялдуулан хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчдын компанид оруулсан хөрөнгийг зүй зохистой захиран зарцуулах, ногдол ашгийг зохистой түвшинд хуваарилах зарчмыг баримтлан, нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээ, нөхцөлийг тухайн санхүүгийн жилийн татвар төлсний дараах цэвэр ашгийн хэмжээ, компанийн богино болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага зэргийг үндэслэн ТУЗ-өөс тогтоохоор “Ногдол ашгийн бодлого”-д тодорхойлсон.



ХУВЬЦАА ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВАХ ХӨТӨЛБӨР

Монложистикс Холдинг ХК (MSE:MLG) нь 4,8 сая ширхэг хувьцаагаа нэгж бүрийг нь 210 төгрөгөөр үнэлж нээлттэй зах зээл дээрээс эргүүлэн худалдаж авахаа зарласан билээ. Хувьцаагаа халаасалсны үр дүнд хувьцааны эрэлт нэмэгдэж, арилжааны идэвхжил сайжрах, хувьцааны үнэ тогтвортой байх, өсөх, хөрөнгө оруулалтын сонирхлыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилготой хөтөлбөр амжилттай хэрэгжиж байна. 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 782,178,689.7 (долоон зуун наян хоёр сая нэг зуун далан найман мянга зургаан зуун наян есөн) төгрөгийн үнийн дүн бүхий хувьцааг нээлттэй зах зээлээс хувьцааны хөрвөн



чадварыг нэмэгдүүлэх зорилгоор эргүүлэн худалдаж аваад байна. Энэхүү хөтөлбөрийг анх зарласан 1,008,000,000 төгрөгийн хувьцааг эргүүлэн худалдаж авахаар үргэлжлэх хугацааг 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгахаар шийдвэрлэсэн.

ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХАРИЛЦАХ СТРАТЕГИ

Монложистикс Холдинг ХК (MSE:MLG) нь олон нийтэд нээлттэй компанийн хувьд хувьцаа эзэмшигчид болон хөрөнгийн зах зээлийн нийт оролцогчдод мэдээллээ илүү нээлттэй, ил тод, хүртээмжтэй хүргэж, оролцогч талуудтай хэрхэн байнгын, зөв харилцаатай байх тал дээр онцгой анхаарч ажиллаж байна.

Хөрөнгө оруулагчидтай харилцах стратегийг компанийн өсөлтийн стратегитэй уялдуулан, богино, дунд болон урт хугацааны стратегийн зорилгыг дараах байдлаар тодорхойлов.

Богино хугацааны IR зорилго: Хөрөнгийн зах зээлийн оролцогчдод салбар, бизнес модель, компаниа ойлгуулах, хоёр талт мэдээллийн урсгалыг сайжруулах

Дунд хугацааны IR зорилго: Олон улсын сайн жишигт нийцсэн IR-г хэрэгжүүлдэг Монгол Улсын үлгэр жишээ компани болох

Урт хугацааны IR зорилго: Монгол Улсад төдийгүй бүс нутгийн хэмжээнд хөрөнгө оруулагчдад ээлтэй, ил тод, ёс зүйтэй, үлгэр жишээ компани болох

Компанийн засаглалын кодекс, Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржээс шаарддаг мэдээллийн ил тод, бүрэн байдлыг хангахаас гадна салбарын мэдлэг, мэдээллийг түгээх зорилгоор “Logistics Weekly” мэдээллийн товхимол, сургалт, уулзалтуудыг тогтмол зохион байгуулж байна. Энэ хөрөнгө оруулагчдад салбарыг ойлгоход туслах бодлогын хүрээн дэх ажил болж байна.

Олон нийтэд мэдээллийг шуурхай хүргэх зорилгоор Фэйсбүүк дэхь Monlogistics Group, Монложистикс Холдинг ХК-ийн Албан ёсны хувьцаа эзэмшигчдийн групп хуудсуудад мэдээллийг тухай бүрт оруулж, 2025 оны эхний хагас жилийн болон 2-р хагас жилийн үйл ажиллагааны тайлан, голлох үзүүлэлт, өсөлт болон стратегийн шинэчлэлүүдийг Earnings Call арга хэмжээгээр дамжуулан олон нийтэд танилцууллаа.

Сингапур улсад 2025 оны 11 дүгээр сард зохион байгуулагдсан Монголын хөрөнгө оруулалтын форумын гол төлөөлөгчид нь Goldman Sachs, J.P. Morgan, Morgan Stanley, Deutsche Bank, BlackRock болон олон улсын хөрөнгө оруулалтын сангууд, хөрөнгө удирдагчид зэрэг 100+ оролцогчтой томоохон арга хэмжээ болсон юм. Монложистикс Холдинг ХК-ийн Гүйцэтгэх захирал Г. Хишигбат тус форумд оролцож, компанийн болон салбарын үйл ажиллагааг оролцогчдод танилцуулж, илтгэл тавьж оролцлоо.





ДЭЛХИЙ РҮҮ ТЭМҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ БРЭНД

Үйл ажиллагааны тайлан 2025

ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Хяналтын тогтолцоог илүү оновчтой,
уян хатан бөгөөд хараат бус
баталгаажилтыг хангах, Дотоод
Аудитороор дамжуулан Төлөөлөн
Удирдах Зөвлөлийн шударга, ил тод
байх, манлайлах үүргийг амжилттай
хэрэгжүүлж байна.

АУДИТ


ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО



ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Монложистикс Групп нь “Гурван шугамын загвар”-ын зарчмаар дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэн, үйл ажиллагааны бүхий л шатанд хяналтыг чиг үүргийнхээ дагуу дараах байдлаар хэрэгжүүлэн ажилладаг.

Дотоод хяналтын тогтолцооны гурван шугамын загвар



I ШУГАМ (Гүйцэтгэгчид)	II ШУГАМ (Бодлогоор зохицуулагчид)	III ШУГАМ (Хараат бус баталгаажуулагч)
- Бизнес нэгжүүд - Үйл ажиллагааны нэгжүүд - Дэмжих нэгжүүд	- Эрсдэлийн удирдлага - Нийцлийн удирдлага - Хяналт - Шинжилгээ (Мониторинг) - Чанарын удирдлага - Мэдээллийн аюулгүй байдал - Санхүүгийн удирдлага - ХАБЭА-н удирдлага	- Дотоод аудит

Монложистикс группийн хэмжээнд бизнесийн үйл ажиллагааг эрсдэлгүй, тогтвортой, хяналттай явуулахад анхаарч, ISO стандартын дотоод аудит, нийцлийн аудит, ТУЗ-ийн дэргэдэх дотоод аудитыг илүү уялдаа холбоотой, нэгдсэн байдлаар, үр дүнтэй зохион байгууллаа. ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитор нь группийн толгой болон охин компаниудын засаглал, эрсдэл, хяналтын тогтолцоонд бие даасан, бодитой баталгаа гаргаж, зөвлөгөө өгч, ТУЗ-ийн дэргэдэх Аудит, эрсдэлийн удирдлагын хороонд ажлаа тайлагнан ажилласан.



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

2025 онд Монложистикс Групп нь Эрсдэлийн удирдлагын тогтолцоогоо ISO 9001:2015 чанарын стандартын шаардлагад нийцүүлэн гүнзгийрүүлж, өмнөх онд баталсан “Эрсдэлийн удирдлагын журам”-ын хэрэгжилтийг бүх охин компаниудад жигд нэвтрүүлэн, бодит үйл ажиллагаанд суурилсан хяналт, тайлагналын тогтолцоог бэхжүүлэн ажиллалаа.

Тайлант хугацаанд группийн хэмжээнд стратегийн, тактикийн болон үйл ажиллагааны түвшний эрсдэлийн үнэлгээг тогтмол шинэчилж, эрсдэлийн бүртгэл, тайлагнал болон хяналтын арга хэмжээнүүдийг охин компани бүрийн онцлогт нийцүүлэх, ISO 9001:2015 стандартын шаардлагын дагуу эрсдэлийг бууруулах арга хэмжээний гүйцэтгэлийг дүгнэх зэрэг сайжруулах алхмуудыг хийлээ. Мөн эрсдэлийн удирдлагыг бизнес төлөвлөлт, гүйцэтгэлийн үнэлгээ, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалттай уялдуулснаар эрсдэлийг зөвхөн хамгаалалт бус, үнэ цэн бий болгох хэрэгсэл болгон ашиглаж тодорхой ахиц гаргав.

Өнгөрсөн онд эрсдэлийн удирдлагын хүрээнд төлөвлөсөн ажлуудын гүйцэтгэл дунджаар 57 хувь байсан нь тогтолцоог нэвтрүүлэх, процесс жигдрүүлэх үе шат үргэлжилж байгааг илэрхийлж байна. Цаашид 2026 онд эрсдэлийн хяналтын арга хэмжээг илүү зорилтот, хэмжигдэхүйц байдлаар хэрэгжүүлж, гүйцэтгэлийг сайжруулах, тайлагналыг боловсронгуй болгоход улам анхаарч ажиллаж байна.



НИЙЦЛИЙН УДИРДЛАГА

2025 онд “Нийцлийн журам”-ын дагуу Монложистикс Группийн бизнесийн үйл ажиллагаанд тулгарч болзошгүй эрсдэлд суурилсан нийцлийн үнэлгээг дараах 5 бүлэгт хамаарах хууль эрх зүй, хэм хэмжээний актуудыг судлаж, шалгах асуултуудыг боловсруулан, үнэлгээ хийж, үл нийцэл бүрийн эрсдэл болон магадлалыг тооцон, залруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Үүнд:

- Тусгай зөвшөөрөл, бүртгэл, бичиг баримтын нийцлийг үнэлэх
- Гэрээний эрх зүй, гэрээний эрсдэлд суурилсан нийцлийг үнэлэх
- Гаалийн хууль тогтоомжийн нийцлийг үнэлэх
- Хөдөлмөрийн харилцааны нийцлийг үнэлэх
- Үйл ажиллагааны гол гол процессуудын нийцлийг үнэлэх

ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хөндөгдөхөөс сэргийлэх үндсэн үүргийнхээ хүрээнд ТУЗ-өөс баталсан “Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам”-ыг хэрэгжүүлэн ажиллаж, Монложистикс Холдинг ХК-ийн хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын болон компанийн эрх ашгийг тэргүүнд тавих, ашиг сонирхлын зөрчил бий болохоос урьдчилан сэргийлэх, сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийг тодорхойлох, хэлцэл байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулах уг журмын дагуу компанийн хэмжээнд хийгдэж буй аливаа хэлцлийг хуулийн дагуу хийгдэж байгаад хяналт тавьж, сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээллийг тухай бүрт олон нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлсэн.

2025 онд их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй дараах хэлцлүүд батлагдсан.

№	Батлагдсан огноо	Тогтоолын дугаар	Хэлцлийн агуулга	Хэлцлийн үнийн дүн
1	2025/04/02	№25/ТУЗ/20	Монложистикс Холдинг ХК-иас группийн охин компаниудтай “Менежментийн үйлчилгээний гэрээ” байгуулах	321,800,000
2	2025/11/11	№25/ТУЗ/47	ТУЗ-ийн ийн дарга, хувьцаа эзэмшигч Л. Ганзоригтын нэр дээр байгаа эзэмших эрхийн гэрчилгээтэй газрыг Монложистикс Экүипмент ХХК руу шилжүүлэн авахтай холбоотой талуудын хооронд “Худалдах, худалдан авах гэрээ” байгуулах	145,083,840

ISO 9001:2015

Бид группийн хэмжээнд олон улсын чанарын удирдлагын тогтолцоог үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлсэн билээ. Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлснээр бид байгууллагынхаа бизнесийн үнэ цэнийг нэмэгдүүлж, үйлчлүүлэгч, харилцагчдадаа найдвартай, тогтвортой бөгөөд чанартай үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэн, урт хугацаанд хамтран ажиллах эрхэм зорилгоо улам баталгаажуулах юм. Австралийн TQCSI олон улсын стандартын баталгаажуулалтын байгууллагаас ISO 9001:2015 стандартын хэрэгжүүлэлтийг магадлан баталгаажууллаа.



Хөндлөнгийн баталгаажуулалт

Монложистикс Холдинг ХК, түүний охин компаниудын 2025 оны 12 дугаар сарын 31-нээрх Нэгтгэсэн санхүүгийн байдал болон уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн болохыг хараат бус, хөндлөнгийн аудит болох Грант Тронтон Аудит ХХК баталгаажуулсан. Тус аудитын хүрээнд Мэдээллийн технологийн шинжээч ажиллаж, компанийн мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн системд хөндлөнгийн аудит хийж, зөвлөмж өгсөн.

ДЭЛХИЙ РҮҮ ТЭМҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ БРЭНД

Үйл ажиллагааны тайлан 2025



САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2025 оны санхүүгийн жилд Монложистикс Групп нь 809 мянган тонн ачаа тээвэрлэж, 285 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, үүнээс 21,5 тэрбум төгрөгийн нийт ашиг, 10 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллалаа.

АУДИТЛАГДСАН

САНХҮҮГИЙН ТАЙЛАН



НЭГТГЭСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Орлогын тайлангийн үзүүлэлт (сая ₮)	2023	2024 (restated)	2025
Борлуулалтын орлого	210,361	294,369	285,252
Борлуулалтын өртөг	(192,253)	(272,477)	(263,766)
Нийт ашиг	18,108	21,893	21,486
Борлуулалт, Удирдлагын зардал	(8,482)	(11,191)	(13,168)
Бусад орлого (зардал)	(35)	(496)	1,655
Үйл ажиллагааны цэвэр ашиг	9,591	10,206	9,974
Санхүүгийн орлого (зардал)	283	1,740	1,836
Татварын өмнөх цэвэр ашиг (EBT)	9,874	11,946	11,810
ОАТ-н зардал		(1,600)	(1,788)
Татварын дараах цэвэр ашиг (EBT)	8,652	10,346	10,022
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)			(624)
Цэвэр ашиг	8,652	10,346	9,397
Толгой компанийн хувьцаа эзэмшигчид	5,925	7,339	6,705
Хяналтын эрхгүй хувь оролцоо	2,438	3,008	2,692
Бүх дэлгэрэнгүй орлого			
Бусад дэлгэрэнгүй орлого	-	(212)	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	(62)	(106)	296
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	8,301	10,028	9,693
Толгой компанийн хувьцаа эзэмшигчид	5,863	7,020	6,969
Хяналтын эрхгүй хувь оролцоо	2,438	3,008	2,724
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	8,301	10,028	9,693
Нэгж хувьцаанд ноогдох ашиг суурь ашиг (алдагдал)	14.97	18.54	17.11
Зарласан ноогдол ашиг		5.40	5.80

НЭГТГЭСЭН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт (сая ₮)	2023	2024 (restated)	2025
Мөнгөн хөрөнгө	22,122	8,709	12,288
Дансны авлага	22,535	40,036	45,546
Богино хугацаат хөрөнгө оруулалт	2,461	1,811	375
Бараа материал	135	8,025	4,503
Урьдчилж төлсөн төлбөр	6,050	21,257	10,436
Бусад эргэлтийн хөрөнгө	1,274	2,242	1,886
Эргэлтийн хөрөнгө	54,577	82,080	75,033
Үндсэн хөрөнгө	1,526	5,466	14,472
Ашиглах эрх бүхий хөрөнгө	952	559	503
Бусад эргэлтийн бус хөрөнгө	553	787	716
Гүүдвил	-	3,463	3,518
Эргэлтийн бус хөрөнгө	3,031	10,275	19,209
Нийт хөрөнгө	57,609	92,355	94,242
Дансны өглөг	12,409	22,059	14,609
Урьдчилж орсон орлого	837	8,004	4,149
Богино хугацаат зээл	17	6,733	9,074
Бусад өглөг	465	457	1,903
Богино хугацаат өр төлбөр	13,728	37,253	29,736
Урт хугацаат өр төлбөр	442	6,452	9,352
Нийт өр төлбөр	14,169	43,705	39,088
Эздийн өмч	39,285	42,325	47,041
Хяналтын эрхгүй хувь оролцоонд	4,154	6,325	8,113
Нийт Эздийн өмч	43,439	48,650	55,154
Нийт өр төлбөр ба Эздийн өмч	57,609	92,355	94,242



НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Мөнгөн гүйлгээний тайлангийн үзүүлэлт (сая.₮)	2023	2024 (restated)	2025
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Мөнгөн орлогын дүн	208,264	286,243	307,557
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	205,059	259,445	286,357
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	15	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	83	167	177
Буцаан авсан албан татвар	-	926	-
Татаас, санхүүжилтийн орлого	-	-	-
Бусад мөнгөн орлого	3,122	25,690	21,023
Мөнгөн зарлагын дүн	203,784	299,841	301,361
Ажиллагчдад төлсөн	5,414	7,616	9,828
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,358	1,921	2,429
Бараа материал худалдан авахад төлсөн	53	38,682	57,453
Ашиглалтын зардалд төлсөн	134	95	219
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	186,877	171,759	180,284
Хүүний төлбөрт төлсөн	10	371	2,623
Татварын байгууллагад төлсөн	4,263	12,310	23,221
Даатгалын төлбөрт төлсөн	338	342	419
Бусад мөнгөн зарлага	5,339	66,745	24,884
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,480	(13,598)	6,196
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
	2023	2024	2025
Мөнгөн орлогын дүн	1,416	9,956	8,519
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	1	215	242
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	416	3,109	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	500	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	604	4,708	7,687
Хүлээн авсан хүүний орлого	394	1,233	590
Хүлээн авсан ногдол ашиг	-	-	-
Мөнгөн зарлагын дүн	3,806	24,418	10,133
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	280	7,862	3,232
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	31	130	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	3,301	7,292	1,334
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	46	1,025
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	195	9,087	4,542
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,390)	(14,462)	(1,614)

САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2023	2024	2025
Мөнгөн орлогын дүн	17,420	59,527	83,630
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	6,431	59,527	83,467
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	10,968	-	163
Төрөл бүрийн хандив	-	0	0
Бусад санхүүгийн мөнгөн орлого	22	-	-
Мөнгөн зарлагын дүн	11,383	44,385	84,369
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	9,832	39,743	80,578
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	584	785	751
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-	-
Төлсөн ногдол ашиг	190	3,823	1,917
Бусад санхүүгийн мөнгөн зарлага	778	34	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	6,037	15,142	(739)
Валютын ханшийн зөрүү	(203)	(495)	(265)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	7,924	13,413	3,579
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,198	22,122	8,709
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	22,122	8,709	12,288



НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Өмчийн өөрчлөлтийн тайлангийн үзүүлэлт (сая ₮)	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн	Хяналтын эрхгүй хувь оролцоо	Нийт дүн
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	119	-	10,188	(212)	29,191	39,285	4,154	43,439
Нягтлан бодох бүртгэлийн залруулга	-	-	-	11	52	63	22	85
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	7,339	7,339	3,008	10,346
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	329	329	342	670
Халаасны хувьцаа	-	(1,427)	-	-	-	(1,427)	-	(1,427)
Нэмж төлөгдсөн капитал	-	-	-	-	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-	-	(106)	(212)	(319)	-	(319)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	(2,945)	(2,945)	(1,200)	(4,145)
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	119	(1,427)	10,188	(307)	33,753	42,325	6,325	48,650
Нягтлан бодох бүртгэлийн залруулга	-	-	-	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	6,705	6,705	2,692	9,397
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	1,692	1,692	(905)	788
Халаасны хувьцаа	-	(1,960)	-	-	-	(1,960)	-	(1,960)
Нэмж төлөгдсөн капитал	-	-	-	-	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-	-	296	-	296	-	296
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	(2,017)	(2,017)	-	(2,017)
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	119	(3,388)	10,188	(11)	40,133	47,041	8,113	55,154

ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ

ТАЙЛАГНАЛЫН НИЙЦЭЛ

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланг Олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")-өөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт ("СТОУС"), Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн, Санхүүгийн тайлангийн Олон Улсын Стандарт 10 "Нэгтгэсэн санхүүгийн Тайлан" стандартын аргачлалыг ашиглан бэлтгэсэн.

БҮРТГЭЛИЙН СУУРЬ

Нэгтгэсэн санхүүгийн тайланг аккрузль сууриар бэлтгэсэн ба үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ, хөрөнгө оруулалт болон тодорхой санхүүгийн хэрэглүүрүүдээс бусад зүйлсийг түүхэн өртгийн сууриар бэлтгэсэн.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН ТОЛИЛУУЛГЫН ВАЛЮТ

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланг үйл ажиллагааны валют буюу Монгол төгрөгөөр толилуулсан.

ГАДААД ВАЛЮТААРХ АЖИЛ ГҮЙЛГЭЭ

Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээг бүртгэхдээ ажил гүйлгээ гарсан өдрийн Монголбанкнаас зарласан албан ханшаар төгрөгт хөрвүүлэн бүртгэдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийг тайлант хугацааны эцэст тайлагналын өдрөөр зарласан албан ханшийг ашиглан дахин хөрвүүлдэг. Мөнгөн бус зүйлсийг дахин хөрвүүлэхгүй бөгөөд бодит үнэ цэнээр бүртгэсэн мөнгөн бус зүйлсийг тухайн бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар, түүхэн өртгөөр хэмжигдэж, гадаадвалютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар тайлагнадаг.

ГАДААД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Гадаад валютаар санхүүгийн тайлан бэлтгэдэг охин компанийн санхүүгийн тайланг нэгтгэхдээ тухайн санхүүгийн тайланг Монгол төгрөгт хөрвүүлдэг. Тайлант үеийн орлого болон зардлыг ажил гүйлгээ гарсан өдрийн спот ханшаар, бүх хөрөнгө ба өр төлбөрийн балансын дансдыг санхүү байдлын тайлагналын өдрөөр зарласан албан ханшаар хөрвүүлэн тайлагнадаг. Хөрвүүлэлтээс үүссэн ханшийн зөрүүний олз, гарзыг эзэмшигчийн өмчийн хэсэгт гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц хэсэгт ангилан толилуулдаг.

МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Мөнгөтэй адилтгах хөрөнгөнд үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай 3 хүртэлх сарын хугацаатай хөрөнгө оруулалт зэргийг хамруулдаг. Мөнгөтэй адилтгах хөрөнгийг хөрөнгө оруулалт болон бусад зорилгоос илүү богино хугацаат өр төлбөрийг барагдуулах зорилгоор эзэмшдэг.

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Групп нь тухайн санхүүгийн хэрэглүүрт хамаарах гэрээний оролцогч тал болсон үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг.

Дансны болон бусад авлага, гэрээний хөрөнгийг хялбаршуулсан аргаар үүссэн тухай бүр нь хүлээн зөвшөөрч нягтлан бодох бүртгэлд тусгадаг. Санхүүгийн өр төлбөрт зээл, дансны болон бусад өглөг, үүсмэл санхүүгийн хэрэгслүүд орох ба ажил гүйлгээг үүссэн өдрөөр хүлээн зөвшөөрч, бүртгэдэг.

БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалыг анх олж авснаасаа хойш түүнийг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар бүртгэж харуулдаг. Үндсэн үйл ажиллагааг явуулахтай холбоотой ашиглагдах хангамжийн зүйлсийг хангамжийн материал гэх дансанд бараа материалын бүртгэлтэй адилаар ангилж бүртгэдэг.

ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Ирээдүйд тухайн хөрөнгөөс эдийн засгийн өгөөж олж авах магадлалтай бөгөөд хөрөнгийн өртгийг үнэн зөв найдвартай хэмжих боломжтой тохиолдолд үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрдөг ба үндсэн хөрөнгийн дараа үеийн хүлээн зөвшөөрөлттэй холбоотойгоор тайлагналдаа хөрөнгийн өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон аливаа үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр тайлагнадаг.

Үндсэн үйл ажиллагаатай холбоотойгоор үүссэн бүх үндсэн хөрөнгүүдийг элэгдүүлэхдээ шулуун шугамын аргыг ашиглан хөрөнгийн элэгдүүлэх дүнг тооцсон хугацааны туршид системтэйгээр хуваарилан орлогын тайланд бүртгэдэг.

БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Биет бус хөрөнгийн анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн хөрөнгийг олж эзэмшсэн аргаас хамааран өртгөөр нь эсхүл бодит үнэ цэнээр бүртгэдэг. Биет бус хөрөнгийг шулуун шугамын аргаар хорогдуулдаг ба хорогдлын зардал, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан өртгөөр нь үнэлэн тайлагнадаг.

БОРЛУУЛАХ ЗОРИЛГООР ЭЗЭМШИЖ БУЙ ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ / БЗЭБЭХ/

БЗЭБЭХ-ийг анх хүлээн зөвшөөрснөөс хойш түүнийг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар бүртгэж харуулдаг. БЗЭБЭХ -ийн үнэ цэнийн өсөлт, бууралтыг тайлант хугацааны ашиг/алдагдлаар хүлээн зөвшөөрнө. БЗЭБЭХ анх хүлээн зөвшөөрөхөд СТОУС 5 стандартын дагуу тухайн хөрөнгийн дансны үнэ болон цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар үнэлэн бүртгэдэг ба тус бүлгийн хөрөнгийг элэгдүүлэхгүй.

ТҮРЭЭС

Гэрээ нь санхүүгийн түрээс эсэх, эсвэл санхүүгийн түрээсийг агуулсан эсэхийг компани нь уг гэрээ үүссэн өдрөөр үнэлдэг. Санхүүгийн түрээс эхлэх өдрөөр санхүү байдлын тайландаа ашиглах эрхийн хөрөнгө болон түрээс өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг. Ашиглах эрхийн хөрөнгийг шулуун шугамын аргаар гэрээний нөхцөл болон тухайн хөрөнгийн ашиглах жилийн аль багаар элэгдүүлдэг. Түрээс эхлэх өдөр өр төлбөрийг тооцоходоо ирээдүйн түрээсийн төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийг түрээсийн нуугдмал хүүний түвшинг (тодорхойлох боломжгүй бол эзэлийн өсөн нэмэгдэх хүүний түвшинг) ашиглан дискаунтчлан тооцдог.

АЖИЛЧДЫН БОГИНО ХУГАЦААНЫ ТЭТГЭМЖ

Ажилчдад олгох богино хугацааны тэтгэмж ажилчид холбогдох үйлчилгээ үзүүлсэн жилийн тайлант хугацааны эцсээс хойш 12 сарын дотор олгох тэтгэмж бөгөөд цалин урамшуулал, ээлжийн амралтын олговор, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нийгмийн даатгалын шимтгэл болон бусад нийгмийн төлбөрүүд багтана.

ТАЙЛБАР ТОЛЬ

Монложистикс Групп эсвэл Групп Монложистикс Холдинг ХК болон түүний охин компаниудыг хамтад нь

Толгой компани Монложистикс Холдинг ХК

Охин компани Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтад заасан хуулийн этгээдүүд

Зэргэлдээ компани Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.15 дахь заалтад заасан хуулийн этгээдүүд

Компанийн нэгдэл Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.14 дэх заалтад заасан хуулийн этгээдүүд

MSE Монголын Хөрөнгийн Бирж

MLG Монложистикс Группийн Монголын хөрөнгийн бирж дээрх символ

ТУЗ Төлөөлөн удирдах зөвлөл

ХЭХ Хувьцаа эзэмшигчдийн хурал

ХХК Хязгаарлагдмал хариуцлагатай компани

ХК Хувьцаат компани

БНХАУ Бүгд Найрамдах Хятад Ард Улс

ОХУ Оросын Холбооны Улс

IPO Нийтэд анх удаа хувьцаа санал болгох

ESG Байгаль орчин, Нийгэм, Засаглал 3 үгийн товчлол

ROE Өөрийн хөрөнгийн өгөөж

ААНОАТ Аж ахуй нэгжийн орлогын албан татвар

VWAP Volume weighed average price / дундаж үнэ/

НББОУСЗ Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл

СТОУС Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт

БЗЗБЭБХ Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө

SWIFT Олон улсын төлбөр тооцооны систем

Subsidy Татаас

ISO Олон улсын стандартчиллын байгууллага

PR Олон нийтийн харилцаа

ХОМК Хөрөнгө оруулалт менежментийн компани

СЭЗИС Санхүү эдийн засгийн их сургууль

ESOP Employee Stock Ownership Plan

KESO Гол ажитнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөрлбөр

ХАБЭАБО Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй байгаль орчин

CoCo Дотоод хяналтын үнэлгээний загвар

Core system Үндсэн систем

Dashboard Интерактив мэдээллийн дүрслэл, дүн шинжилгээ хийх хэрэгсэл

ERP Нэгдсэн нөөцийн төлөвлөлтийн систем

RPA Процессын автоматжуулалт

DMS Баримт бичгийн менежемент

LMS Тээврийн бүртгэлийн систем

DWH Өгөгдлийн нэгдсэн сан

AI Хиймэл оюун ухаан

IoT Интернэтэд холбогдсон, өгөгдөл цуглуулж, солилцох чадвартай ухаалаг төхөөрөмжүүдийн сүлжээ

WTO Дэлхийн худалдааны байгууллага

Investor relation Хөрөнгө оруулагчтай харилцах

M&A Нэгдэх, худалдан авах замаар компанийг өөртөө нэгтгэх

B2B Бизнесээс бизнесүүдтэй хийх борлуулалт

B2C Бизнесээс хэрэглэгчдэд хийх борлуулалт

OPT Тээврийн менежмент үзүүлэлт

ТАЙЛБАР ТОЛЬ

Тохируулах
бичилт

Группийн аж ахуй нэгж хооронд
хийгдсэн гүйлгээ, үлдэгдлийг
устгах бичилт

Restated

Дахин тайлагнасан санхүүгийн
тайлан

Нийт ашгийн хувь

=

Нийт ашиг * 100

Борлуулалтын орлого

Цэвэр ашгийн хувь

=

Цэвэр ашиг * 100

Борлуулалтын орлого

Өөрийн хөрөнгийн
өгөөж

=

Тайлант үеийн ашиг

Эздийн өмч

Өөрийн хөрөнгийн
харьцаа

=

Монложистикс группийн эздийн өмч

Нийт хөрөнгө

Үйл ажиллагааны
эргэц

=

360

Худалдан авалт

×

Дундаж бараа

материал

+

360

Авлага

×

Дундаж

авлага

Эргэлтийн харьцаа

=

Эргэлтийн хөрөнгө

Богино хугацаант өр төлбөр

Түргэн хөрвөх
хөрөнгийн харьцаа

=

Эргэлтийн хөрөнгө - Бараа материал


Богино хугацаант өр төлбөр

Нэгж хувьцаанд
ногдох суурь ашиг

=

Монложистикс ногдох тайлант үеийн ашиг

Хувьцаа тоо ширхэг



Холбоо барих

Telephone: +976 7701-5454

Website: www.monlogistics.mn

Хаяг

Монгол улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Нью горизонтс оффис,
11 давхар, 1101 тоот

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК-ИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/				
Тайлагнах хугацаа		2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр		
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар		Үнэт цаас гаргагчийн нэр: Монложистикс холдинг ХК Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 6381251 Үнэт цаасны код: MN00MLG05696 Утасны дугаар: 7701-5454		
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр		Монголын хөрөнгийн бирж		
Бизнесийн үйл ажиллагааны салбар		Тээврийн салбар		
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо		Гранд Торнтон Аудит ХХК бүртгүүлсэн огноо: 2017-05-15		
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг		395,858,822		
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр		Бэлтгэсэн: Ц. Дуламсүрэн /ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга/ Хянасан: Г.Хишигбат /Гүйцэтгэх захирал/		
1.	Хагас жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргав/			
a	Санхүүгийн байдлын үзүүлэлт	Мянган төгрөгөөр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		Эргэлтийн хөрөнгийн дүн	82,080,343,130	75,033,076,819
		Эргэлтийн бус хөрөнгийн дүн	10,274,967,186	19,208,507,140
		Нийт хөрөнгийн дүн	92,355,310,317	94,241,583,959
		Өр төлбөрийн нийт дүн	43,704,812,579	39,087,679,730
		Эздийн өмчийн дүн	48,650,497,801	55,153,904,229
		Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	92,355,310,379	94,241,583,959
		b	Орлогын тайлан	Мянган төгрөгөөр
Борлуулалтын орлого	294,369,461,808			285,252,153,729
Нийт ашиг	21,892,912,733			21,486,274,766
Татвар төлөхийн өмнөх ашиг	11,946,259,928			11,809,799,984
Орлогын татварын зардал	(1,599,812,091)			(1,788,048,048)
Татварын дараах ашиг	10,346,447,837			10,021,751,936

с	Өмчийн оорчлолтийн тайлан	Мянган төгрөгөөр	2024 он	2025 он
		Өмч	118,758	118,758
		Халаасны хувьцаа	(1,427,400)	(3,387,613)
		Нэмж төлөгдсөн капитал	10,187,611	10,187,611
		Гадаад валютын хөрөөүүлэлтийн нөөц	(306,648)	(10,709)
		Хуримтлагдсан ашиг	33,752,909	40,133,283
		Нийт дүн	42,325,230	47,041,330
		Хяналтын эрхгүй хувь оролцоо	6,325,268	8,112,574
		Нийт дүн	48,650,498	55,153,904
d	Мөнгөн гүйлгээний тайлан	Мянган төгрөгөөр	2024 он	2025 он
		Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(13,598,306,498)	6,196,346,212
		Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(14,461,998,898)	(1,614,018,091)
		Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	15,142,180,461	(739,160,385)
		Валютын ханшийн зөрүү	(494,872,454)	(264,540,241)
		Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(13,412,997,389)	3,578,627,494
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	22,121,885,166	8,708,887,778
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,708,887,778	12,287,515,272
1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	Дүгнэлт Бид Монложистике Холдинг ХК (цаашид “компани” гэх) болон түүний охин компаниуд (хамтад нь “групп” гэх)-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-нээрх дараах санхүүгийн тайлангууд (цаашид “санхүүгийн тайлан” гэх)-д аудит хийлгээ. Үүнд: - Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан; - Нэгтгэсэн орлогын дэлгэрэнгүй тайлан; - Нэгтгэсэн өмчийн оорчлолтийн тайлан; - Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон - Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй; - Материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл болон бусад тайлбар тодруулгууд бидний дүгнэлтээр, Монложистике Холдинг ХК болон түүний охин компаниуд (хамтад нь “Групп” гэх)-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-нээрх Нэгтгэсэн санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн СТОУС нягтлан бодох бүртгэлийн стандартуудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.		
2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл			
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/			
	- Нийт актив: 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт актив 94 тэрбум төгрөгт хүрч, 2024 оны эцэстэй харьцуулахад 2%-ийн өссөн үзүүлэлттэй байна. - Нийт өөрийн хөрөнгө: Нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 55 тэрбум төгрөгт хүрч, 2024 оны эцэстэй харьцуулахад 13%-ийн өссөн үзүүлэлттэй байна. - Ашигт ажиллагаа: 2025 оны жилийн эцсээр группийн нэгтгэсэн санхүүгийн тайлангаар татварын дараах цэвэр ашиг 10,0 тэрбум төгрөгт хүрсэн байна.			

2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нооц, боломжийн үзүүлэлт:	Харьцаанууд	2024 он	2025 он
		Нийт ашгийн хувь	7.4%	7.5%
		Цэвэр ашгийн хувь	3.5%	3.5%
		Өөрийн хөрөнгийн өгөөж	21%	19%
		Нэгж хувьцаанд ноогдох ашиг	18.54	17.11
		Харьцаанууд	2024 он	2025 он
		Эргэлтийн харьцаа	2.20	2.52
		Түргэн хөрвөх чадварын харьцаа	1.36	1.96
		Өрийн харьцаа	47%	46%
2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл: 2025 онд Монложистике Групп нь зах зээлийн тийм ч таатай биш нөхцөлд эрсдэлийг удирдах, боломжийг ашиглах, стратегийн чиглэлээ оновчтой тодорхойлоход тодорхой ахиц гарган ажиллаж цаашид экспортын тээврийг нэмэгдүүлэх, бүрэн дижитал үйл ажиллагааг нэвтрүүлсэн тээвэр, ложистикийн компани болох, бүс нутгийн интеграцид идэвхтэй оролцох зорилтыг хэрэгжүүлэх суурь бүрдсэн жил боллоо. 2026 онд тээврийн салбарын орлого 11.2 их наяд хүрч, салбар 18 хувиар өсөх хүлээлттэй байна. Гэхдээ энэхүү хүлээлт нь гадаад зах зээлийн нөхцөл байдал болон макро эдийн засгийн бодлогоос үлэмж хамааралтай. Дээрх өсөлтийг дэмжих гол хүчин зүйлс нь: • Зэсийн олборлолт болон зах зээлийн үнэ өсөх • Нүүрсний үнэ тогтворжиж, цаашид өсөх • Хилийн боомтуудын нэвтрүүлэх чадвар сайжрах • Томоохон бүтээн байгуулалтын төслүүдтэй холбоотой импортын тээвэр нэмэгдэх • Транзит тээврийн ачаа нэмэгдэх зэрэг байна гэж харж байна. 2026 онд Монложистике группийн хувьд дэд бүтцийн хөрөнгө оруулалтын хөгжүүлэлт, олон улс дах салбарын хөгжүүлэлт, дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулах, олон улсаас хөрөнгө оруулалт татах судалгаа хийх үэрэг дунд болон урт хугацааны стратеги дээр төвлөрч ажиллах жил байхаар төлөвлөж байна.			
	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/: Санхүүгийн тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй болно.			
2.4.				

2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл			
	24.1 Богино болон урт хугацаат зээл			
	Мянган төгрөгөөр	Богино хугацаат		Урт хугацаат
		2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
	Банкны зээллэг	5,197,985	6,733,065	9,189,752
				5,871,030
	Зээлийн дүн		5,197,985	6,733,065
			9,189,752	5,871,030
	25. Хаалттай бондын өр төлбөр			
	Мянган төгрөгөөр	Богино хугацаат		
		2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	
	Төгрөгийн бонд (1)		4,000,000	2,500,000
	Бондын хүүгийн өглөг (2)		137,836	-
	Бондын өр төлбөрийн дүн		4,137,836	2,500,000
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/ Монложистик Холдинг ХК-ийн ТУЗ-өөс Компанийн тухай хууль болон “Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам”-ын дагуу дараах хэлцлүүдийг ТУЗ-оор хэлэлцэж, баталсан.			
	№	Батлагдсан огноо	Тогтоолын дугаар	Хэлцлийн агуулга
	1	2025/04/02	№25/ТУЗ/20	Монложистикс Холдинг ХК-иас группийн охин компаниудтай “Менежментийн үйлчилгээний гэрээ” байгуулах
4	2	2025/11/11	№25/ТУЗ/47	ТУЗ-ийн ийн дарга, хувьцаа эзэмшигч Л. Ганзоригтын нэр дээр байгаа эзэмших эрхийн гэрчилгээтэй газрыг Монложистикс Экүймент ХХК руу шилжүүлэн авахтай холбоотой талуудын хооронд “Худалдах, худалдан авах гэрээ” байгуулах
				Хэлцлийн үнийн дүн
				321,800,000
				145,083,840
4	Цалин урамшууллын мэдээлэл:			
	2024 оны 4-р сард хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн батлуулсан ТУЗ-ийн гишүүдийн цалинд 2025 онд өөрчлөлт ороогүй бөгөөд компанийн жилийн төсвийн хүрээнд ТУЗ-ийн гишүүдэд үндсэн цалин болон хорооны даргын нэмэгдэл, хорооны гишүүний нэмэгдлийг тус тус тогтмол дүнгээр тооцож, дараах нийт цалинг ТУЗ-ийн гишүүдэд олгосон.			
	№	Зардлын задаргаа		Нийт зардал
	1	ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардал		182,400,000 ₮
	2	Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал		22,800,000 ₮
	НИЙТ ЗАРДЛЫН ТӨСӨВ		205,200,000 ₮	
	Гүйцэтгэх удирдлагын цалин урамшуулал нь ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан үндсэн цалин болон жилийн эцсийн ашигт ажиллагаа, стратегийн гүйцэтгэлээс хамаарсан урамшуулалт цалингаас бүрдэнэ.Тайлант онд гүйцэтгэх захирлын үндсэн цалинг нэмэгдүүлээгүй бөгөөд урамшуулал олгох шалгуур үзүүлэлт өөрчлөгдөөгүй.			

	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл: 1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Монложистике Холдинг ХК-ийн эрх барих дээд байгууллага болох хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр 87.74%-ийн ирцтэйгээр амжилттай зохион байгуулагдсан.Хурлыг хувьцаа эзэмшигчдийн хурлын платформыг ашиглан зайнаас буюу цахим хэлбэрээр хуралдуулж, шууд дамжуулалтыг хурлын платформоор болон фэйсбүүк дэхь Monlogistics Group пэйж хуудсаар олон нийтэд хүргэсэн.Хувьцаа эзэмшигчдийн хуралд: 1. Гүйцэтгэх захирал бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Г.Хишигбат компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлахын өмнө компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг товч танилцуулж; 2. ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудит, Эрсдэлийн удирдлагын хорооны дарга Э.Оюунбилэг компанийн ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж; 3. Хөндлөнгийн аудитор Грант Торнтон ХХК-ийн аудитын багийн гэрээт ажлын партнер Н.Эрдэнэцог компанийн санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг тус тус танилцуулж, хувьцаа эзэмшигчдээс ирсэн асуултанд хариулж оролцсон. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар: Монложистике Холдинг ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батласан. 2. ТУЗ-ийн ажлын товч тайлан Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл юм. Хурдацтай өөрчлөгдөж буй бизнесийн талбарт үүсч болох эрсдэл ба боломжийг амжилттай удирдах чадвартай, салбар салбартаа мэргэшсэн, туршлагатай гишүүдээс Монложистике Холдинг ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл бүрддэг бөгөөд ердийн 5, хараат бус 4, нийт 9 гишүүнтэй. Тайлант хугацаанд ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй болно. i. ТУЗ-ийн хурал Монложистике Холдинг ХК-ийн ТУЗ нь 2025 онд ээлжит болон ээлжит бус нийт 7 удаагийн хурал зохион байгуулж, гишүүд идэвх санаачлагатай оролцсон бөгөөд хурлын дундаж ирц 88%.Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд ТУЗ-ийн хурал болон ТУЗ-ийн гишүүдээс эцнээ санал хураалт явуулах замаар 2025 онд ТУЗ-өөс нийт 50 тогтоол шийдвэрийг баталсан. ii. ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурал ТУЗ-ийн дэргэдэх хороод нь 2025 онд биечлэн болон цахим хэлбэрээр нийт 18 удаа хуралдаж, хороодын ажлын чиг үүргийн дагуу идэвх санаачлагатай ажилласан.Аудит, эрсдэлийн удирдлагын хороо нь компанийн эрсдэл, комплайнс, санхүү, нягтлан бодох бүртгэлийн удирдлагад хөндлөнгийн аудиторуд болон Дотоод аудитор, нийцэл хариуцсан ажилтнаар дамжуулан хяналт тавих, удирдан чиглүүлэх өргөн чиг үүрэгтэй ажилладаг бөгөөд 2025 онд нийт 8 удаагийн хурал, 2 удаагийн ажлын уулзалтаар нийт 11 зөвлөмж, дүгнэлт гарган ажилласан байна. 3. Хяналтын тогтолцоо Монложистике Группийн бизнесийн үйл ажиллагааг эрсдэлгүй, тогтвортой явуулахад хяналтын тогтолцооны хүрээнд анхаарч, 2025 онд дараах чиглэлээр хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд: • Компанийн засаглал, мөрдөгдөж буй дүрэм журам, эрх зүйн баримт бичгүүдийн нийцлийг үнэлэх, зөвлөмж өгөх нийцлийн аудит; • Чанарын удирдлагын тогтолцооны ISO стандартын хэрэгжилтийг үнэлэх, үр дүнтэй, үр нөлөөтэй байдлыг хангах, сайжруулах боломжийг тодорхойлох дотоод аудит; • ТУЗ-ийн дэргэдэх хараат бус дотоод аудит;
6	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл: Дэлхийн геополитикийн нөхцөл байдал урьдчилан таамаглахад бэрх, бүс нутгийн зөрчил хуршадмал, томоохон эдийн засагтай улс гүрнүүдийн хооронд худалдаа, хамтын ажиллагаа суларсан, тодорхойгүй байдал давамгайлсан нь дэлхийн худалдаанд тодорхойгүй байдлын эрсдэлийг нэмэгдүүлж байна. 2022 онд эхэлсэн ОХУ–Украины дайны нөлөө 2025 онд улам гүнзгийрч, Ази– Европын хоорондын уламжлалт тээврийн урсгалд дараах өөрчлөлтүүдийг авчирч байна. АНУ–БНХАУ-ын худалдааны харилцаа 2025 оны хоёрдугаар хагаст тодорхой хэмжээнд тогтворжсон хэдий ч компаниуд геополитикийн эрсдэлээ бууруулах зорилгоор “China Plus One (C+1)” стратегийг эрчимтэй хэрэгжүүлж эхэлсэн.

Ногдол ашгийн мэдээлэл

“Монложистикс Холдинг” ХК-ийн үйл ажиллагаа болон стратегийн бодлоготой уялдуулан хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчдын компанид оруулсан хөрөнгийг зүй зохистой захиран зарцуулах, ногдол ашгийг зохистой түвшинд хуваарилах зарчмыг баримтлан, нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээ, нөхцөлийг тухайн санхүүгийн жилийн татвар төлсний дараах цэвэр ашгийн хэмжээ, компанийн богино болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага зэргийг үндэслэн ТУЗ-өөс тогтоохоор “Ногдол ашгийн бодлого”-д тодорхойлсон.

2025 оны санхүүгийн жилд ногдол ашиг тараана.

9.

цэвэр ашгийн	23.9%
нийт	2,295,981,167.60₮
нэгж хувьцаанд	5.80₮
ногдол ашиг тараах өдөр	2026.04.30

Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл

10.

Монложистикс группийн урт хугацаанд тогтвортой, өрсөлдөх чадвартай хөгжиж, алсын хараа болон эрхэм зорилгодоо хүрэх үндэс суурийг бий болгоход чиглэсэн Тогтвортой хөгжлийн бодлогын баримт бичгийг Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталлаа. Компанийн бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлж болох гадаад, дотоод орчны эрсдэл, боломжуудыг тогтмол үнэлж, үр нөлөөтэй удирдан зохицуулах замаар оролцогч талуудад үнэ цэн бүтээх тогтолцоог хөгжүүлэх удирдлагын амлалтын мөн Тогтвортой хөгжлийн бодлогод тусгаж өгсөн.

Үйл ажиллагааны жилийн дэлгэрэнгүй тайлантай танилцаж, нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийн чиглэлээр хийсэн ажлуудтай танилцана уу.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Г. Хишигбат

Албан тушаал: “Монложистикс холдинг” ХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: 2026-04-20

Овог, нэр: Ц. Дуламсүрэн

Албан тушаал: ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга

Гарын үсэг: